



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠨᠠᠭ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ  
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТӨД ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО ХАНГАЛТГҮЙ,  
ИРГЭДИЙН САНАЛААР ДЭМЖИГДЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛЖ  
ХЭРЭГЖҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ АРИЛАХГҮЙ БАЙНА

АУДИТЫН КОД:

АРА-2025/31-01-ШТА-ГА



ЦЭЦЭРЛЭГ ХОТ  
2025 ОН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Алтантуяа

Цахим хаяг: altantuyan@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх

Цахим хаяг: soyolmunkhl@audit.gov.mn

Аудитор А.Пүрэвцэцэг

Цахим хаяг: purevtsetsega@audit.gov.mn

Аудитор Э.Нямсүрэн

Цахим хаяг: nyamsurene@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



<p><b>Тайлан бэлтгэсэн:</b> Архангай аймаг дахь Төрийн аудитын газар</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Товчилсон үгийн тайлбар .....2</li> <li>➤ Аудитын зорилт, арга, зүй стандартын талаар .....3-4</li> <li>➤ Үндсэн мэдээлэл .....5-6</li> <li>➤ Аудитын тайлан ..... 7-50</li> </ul>
<p><b>Тэргүүлэх аудитор</b> <b>Т.Байгалмаа</b></p> <p><b>Аудитын менежер</b> <b>Д.Нэргүйбаатар</b></p> <p><b>Ахлах аудитор</b> <b>Н.Алтантуяа</b> <b>Аудитор</b> <b>Л.Соёлмөнх</b> <b>А.Пүрэвцэцэг</b> <b>Э.Нямсүрэн</b></p> <p>2025 оны 07 дугаар сар Уг тайланг <a href="http://www.openaudit.mn">www.openaudit.mn</a> сайтаас үзнэ үү.</p>	<p><b>БҮЛЭГ 1. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТӨД ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗӨРЧИЛ ДАВТАГДСААР БАЙНА</b></p> <p><b>1.1. АРХАНГАЙ АЙМАГТ ОНХНС-ААС ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ 504.4 САЯ ТӨГРӨГӨӨР ДУТУУ ХУВААРИЛСАН БАЙНА</b></p> <p><b>1.2. СУМДЫН ИТХ НЬ ИРГЭДИЙН САНАЛААР ДЭМЖИГДЭЭГҮЙ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛТЭЙ УЯЛДААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛДАГ ЗӨРЧИЛ ДАВТАГДСААР БАЙНА</b></p> <p><b>БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 97.3 ХУВЬ НЬ ЗОРИЛТОД ТҮВШИНД ХҮРСЭН БАЙНА.</b></p> <p><b>2.1. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БАРИМТЛАН АЖИЛЛАЖ БАЙГАА ХЭДИЙ Ч ЗАРИМ СУМД САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ОЛГООГҮЙ БАЙНА</b></p> <p><b>2.2. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 97.3 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА</b></p> <p><b>2.3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ САЙЖИРСАН БАЙНА</b></p> <p><b>БҮЛЭГ 3.ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТЫН 86.7 ХУВЬД ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА</b></p> <p><b>3.1. ОНХС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА</b></p> <p><b>3.2. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД БҮРЭН МЭДЭЭЛЭЭГҮЙ, 472.6 САЯ ТӨГРӨГИЙН 3 ТАХ-Г БҮРТГЭЛ ТАЙЛАНД ТУСГААГҮЙ БАЙНА</b></p> <p>Дүгнэлт..... 31 Зөвлөмж .....32-33 Холбогдох байгууллагын санал ..... 34 Тайлан баталгаажуулсан тушаал..... 35-37 Хавсралт:Судалгаанууд .....39-50</p>
<p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860, 7033-3141 дугаарын утсаар харилцана уу</p>	
<p>Хаяг: Цэцэрлэг хот Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот</p>	



## Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМАТЗ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
ГТНАТ	Газрын тосны нөөц ашигласны төлбөр
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЖГҮ	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХДАХ	Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ХАА	Худалдан авах ажиллагаа

## Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл	6
Хүснэгт 2	ОНХС-ийн төлөвлөлт	7
Хүснэгт 3	ОНХС-ийн суурь тооцоолол	8
Хүснэгт 4	Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт	9
Хүснэгт 5	ОНХС-ийн эх үүсвэр	10
Хүснэгт 6	ОНХС-ийн 2024 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ	18
Хүснэгт 7	ТАХ-ний зорилтот түвшинд хүрсэн байдал	19
Хүснэгт 8	Хөрөнгийн ашиглалтын байдал	20
Хүснэгт 9	ОНХС-ийн хяналт аймаг, нийслэлээр	25
Хүснэгт 10	Удирдлагын мэдээллийн системийн мэдээлэл	29

## Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Иргэдийн санал өгсөн байдал	12
Дүрслэл 2	Иргэдийн санал авсан болон аваагүй ТАХ	13
Дүрслэл 3	Аймаг, нийслэлийн чиг үүрэг	15
Дүрслэл 4	Сум, дүүргийн чиг үүрэг	15
Дүрслэл 5	Тендер, ХАА зохион байгуулалт	16
Дүрслэл 6	Ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ ТАХ-ний тоогоор	20
Дүрслэл 7	ОНХС-ийн хяналт	24
Дүрслэл 8	Захиалагчийн хяналт	25



## **АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 тушаалаар баталсан “Аудитын жилийн төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө” -г үндэслэн гүйцэтгэв.

### **Аудитын зорилт**

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

### **Аудитын хамарсан хүрээ**

Аудитад Сангийн яам болон аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хороодын Засаг дарга, аймаг, сумын ОНХС-ийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, ОНХС-ийн “Удирдлагын мэдээллийн систем”-ийн үйл ажиллагааг хамруулав.

### **Аудитын арга зүй**

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817- 1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

### **Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:



- ✓ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- ✓ Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Н.Алтантуяа, аудитор Л.Соёлмөнх, А.Пүрэвцэцэг, Э.Нямсүрэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2025.05.01 - 2025.07.01-ний хооронд хийж гүйцэтгэлээ.



## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Орон нутгийн хөгжлийн сангийн (цаашид ОНХС гэх) зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

ОНХС нь нутгийн иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэрэгсэл бөгөөд тухайн орон нутгийн иргэд нь өөрсдөө тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөлд оролцох боломжтой юм.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-д "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан" гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгө" гэж тодорхойлсон байдаг.

Төсвийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйлд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (цаашид ОНХС гэх) болон ОНХС-ийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, хуваарилалтыг зохицуулсан бөгөөд ОНХС-ийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "ОНХС-ийн үйл ажиллагааны журам", 2024 оноос ОНХС болон ОНХС-аас орлогын шилжүүлгийг тооцож олгоход "Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ыг мөрдөж байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар ОНХС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг Архангай аймагт 12,118.9 сая төгрөгөөр баталсныг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн "Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулиар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого өссөнтэй уялдуулан 571.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн орлогын шилжүүлгийг 12,690.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 12,186.4 сая төгрөгийг олгожээ.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 60.2.4<sup>1</sup>, 60.2.8<sup>2</sup>-д заасны дагуу аймаг, сумдын ИТХ-аар ОНХС-ийн орлогын шилжүүлгээс гадна 5,244.5 сая төгрөгийн эх үүсвэрийг нэмж баталсан байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн эхний үлдэгдэл 3,091.7 сая төгрөг, сангийн эх үүсвэрт нийт 17,935.3 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 14,272.6 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 3,010.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

<sup>1</sup> 60.2.4. татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

<sup>2</sup> 60.2.8. малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардал зарцуулна.



## Хүснэгт №1. ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

№	Аймаг, нийслэл нэр	ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл	Нийт эх үүсвэр		Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх зарлагын нийт дүн	ОНХС-ийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 5=1+3-4
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
А		1	2	3	4	5=1+3-4
1	Ихтамир	157.8	721.8	459.8	511.6	106.0
2	Чулуут	105.6	500.7	413.6	465.6	53.7
3	Хангай	89.3	364.3	274.9	323.2	41.0
4	Тариат	105.9	518.2	384.5	402.4	88.0
5	Өндөр-Улаан	32.0	487.0	443.8	374.0	101.8
6	Эрдэнэмандал	72.3	576.0	473.0	489.6	55.6
7	Жаргалант	309.9	686.9	357.0	608.8	58.1
8	Цэцэрлэг	156.8	487.6	288.6	265.4	180.0
9	Хайрхан	27.7	338.8	341.3	272.8	96.2
10	Батцэнгэл	223.9	512.6	359.4	423.9	159.4
11	Өлзийт	40.3	341.8	341.8	172.8	209.4
12	Өгийнуур	73.2	309.2	245.5	269.9	48.8
13	Хашаат	39.2	437.3	368.0	362.7	44.6
14	Хотонт	81.3	456.4	414.2	388.1	107.3
15	Цэнхэр	157.0	1,648.4	1,256.8	1,012.1	401.7
16	Төвшрүүлэх	27.8	1,361.0	1,035.7	849.0	214.5
17	Булган	81.4	337.9	266.2	302.5	45.1
18	Эрдэнэбулган	117.2	922.7	728.4	674.7	171.0
19	Цахир	38.1	289.0	250.9	109.9	179.1
	Сумдын дүн	<b>1,936.6</b>	<b>11,297.6</b>	<b>8,703.6</b>	<b>8,279.0</b>	<b>2,361.3</b>
20	Аймаг	1,155.1	6,637.8	5,487.7	5,993.6	649.2
	<b>Нийт дүн</b>	<b>3,091.7</b>	<b>17,935.3</b>	<b>14,191.4</b>	<b>14,272.6</b>	<b>3,010.5</b>

Өмнөх аудитаар нийт 5,078.9 сая төгрөгийн зөрчил арилгах, таслан зогсоох 45 албан шаардлага, 3 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсний шийдвэрийн хэрэгжилтийг үнэлж үзэхэд хэрэгжилт дунджаар 83.7 хувьтай байна.

*Аудитын явцад ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн идэвх оролцоо, мэдээлэл ямар байгааг судлах, нэгтгэн дүгнэж аудитын тайланд тусган холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал зөвлөмжийг боловсруулах зорилгоор судалгаа, санал асуулгыг гүүгл форум (google forum) ашиглан 229 иргэнээс цахимаар санал авч нэгтгэн дүн шинжилгээ хийж, тайланд тусгав.*



## БҮЛЭГ 1: ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТӨД ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗӨРЧИЛ ДАВТАГДСААР БАЙНА

### 1.1 Архангай аймагт ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 504.4 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна

1.1.1. ОНХНС-аас Архангай аймагт олгох орлогын шилжүүлгийн эх үүсвэрийн 92.1 хувийг газрын тосны нөөц ашигласны төлбөр (ГТНАТ), 2.6 хувийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ), 0.9 хувийг ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, 4.4 хувийг “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ”-ний урамшууллаас бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт №2. ОНХС-ийн төлөвлөлт

(сая төгрөг)

ОНХС-ийн орлогын эх үүсвэр		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	Газрын тосны нөөц ашигласны төлбөр -30%	11,683.8	11,263.0	420.8	96.4
	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр -10%	333.5	249.9	83.6	74.9
Улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр - 100 %	0.7	0.7	-	100.0
	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр - 50%	118.0	118.0	-	100.0
Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, ҮА-ны үнэлгээ / ЖГҮ/		554.8	554.8	-	100.0
Аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн нийт дүн		12,690.8	12,186.4	504.4	96.0

Эх сурвалж: Сангийн Яам, аймгийн СТСХ

Аймгийн ОНХС-ийн санхүүжилтийн эх үүсвэрийг ОНХНС болон улсын төсвөөс нийт 12,690.8 сая төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 12,186.4 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилжээ. Энэ нь улсын хэмжээнд газрын тосны болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого тасарснаас шалтгаалж, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 420.8 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 83.6 сая төгрөг, нийт 504.4 сая төгрөгийн санхүүжилт аймагт дутуу олгогдсон байна.

Архангай аймагт 2023 онд ОНХНС-аас 10,740.4 сая төгрөгийг төлөвлөж, 10,571.3 сая төгрөгийг олгож байсан бол 2024 оны төсвийн тодотголоор 12,690.8 сая төгрөгөөр төлөвлөн, 12,186.4 сая төгрөгийг олгож, өмнөх оноос санхүүжилт 1615.1 сая төгрөг буюу 13.3 хувиар өссөн байна.

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3 дахь заалтууд, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу хүн амын тоо, нутаг дэвсгэрийн болон ашигт малтмалын ашиглалтын талбайн хэмжээ зэрэг шалгуур үзүүлэлтэд үндэслэн тооцсон байна.



ОНХС-ийн суурь тооцооллыг аймаг, сумдаар авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №3. ОНХС-ийн суурь тооцоолол

(сая төгрөг)

№	Сум	Итгэлцүүрээр хуваарилагдах нийт дүн	Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ /ЖГҮ/	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Аймаг, Сумдын ОНХС-д хуваарилагдах суурь дүн
1	Батцэнгэл сум	286.9	-	-	1.8	288.7
2	Булган сум	213.5	-	-	-	213.5
3	Жаргалант сум	235.0	-	-	-	235.0
4	Ихтамир сум	378.4	-	-	1.1	379.4
5	Өгийнуур сум	152.9	48.6	-	-	201.4
6	Өлзийт сум	180.2	48.6	-	1.0	229.8
7	Өндөр-Улаан сум	341.3	-	-	-	341.3
8	Тариат сум	298.9	-	0.1	0.9	300.0
9	Төвшрүүлэх сум	1,192.2	-	-	54.7	1,246.9
10	Хайрхан сум	204.5	63.3	-	-	267.8
11	Хангай сум	274.9	-	-	-	274.9
12	Хашаат сум	193.2	56.9	-	-	250.1
13	Хотонт сум	215.7	-	0.5	-	216.3
14	Цахир сум	212.6	-	-	-	212.6
15	Цэнхэр сум	1,399.1	61.3	-	56.5	1,517.0
16	Цэцэрлэг сум	208.3	70.3	-	-	278.6
17	Чулуут сум	393.1	-	-	1.9	395.1
18	Эрдэнэбулган сум	540.3	115.2	-	-	655.5
19	Эрдэнэмандал сум	289.2	90.6	-	-	379.8
<b>Сумын дүн – 60%</b>		<b>7,210.4</b>	<b>554.8</b>	<b>0.7</b>	<b>118.0</b>	<b>7,883.8</b>
20	Аймаг -40%	4,807.0	-	-	-	4,807.0
<b>Нийт дүн</b>		<b>12,017.4</b>	<b>554.8</b>	<b>0.7</b>	<b>118.0</b>	<b>12,690.8</b>

Эх сурвалж: Сангийн Яам, аймгийн СТСХ

Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолын дагуу орлогын шилжүүлгийн суурь тооцооллоор аймаг, сумын ОНХС-д 12,017.4 сая төгрөг, өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээгээр 554.8 сая төгрөг, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 100% болох 0.7 сая төгрөг, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50% болох 118.0 сая төгрөг, нийт 12,690.8 сая төгрөгийг тооцож төлөвлөснөөс сумдад 7,883.8 сая төгрөгийг хуваарилжээ.

Аймгийн Цэнхэр, Төвшрүүлэх сумдад итгэлцүүрээр хуваарилагдах дүн бусад сумдтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа нь ашигт малтмалын ашиглалтын талбайн хэмжээнээс хамааруулан орлогын шилжүүлгийг тооцон төлөвлөсөнтэй холбоотой байна.



Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээгээр аймгийн 19 сумаас 8 сум нийт 554.8 сая төгрөгийн санхүүжилт авсан бол бусад 11 сум нь энэ боломжийг алдсан байна. Цаашид дээрх сумд нь ОНХС-ийн удирдлага мэдээллийн системд сангийн төлөвлөлт, зарцуулалтын мэдээллийг тухай бүр мэдээлж, үйл ажиллагааны үнэлгээг хийлгэн, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах шаардлагатай байна.

**1.1.3.** Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн “Аймгийн 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 07 дугаар тогтоол, Сангийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” 152 дугаар тушаалд үндэслэн Аймгийн засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 17-ны А/762 дугаар захирамжаар ОНХС-ийн сар, улирлын хуваарийг баталсан байна.

Батлагдсан хуваарийн дагуу аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт олгосон байдлыг улирлаар нэгтгэн авч үзвэл:

Хүснэгт № 4. Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт

(сая төгрөг)

Санхүүжилт улирлаар	Аймаг, сум	Сар, улирлын санхүүжилтийн хуваарь	Гүйцэтгэл	Зөрүү
1-р улирал	Аймаг	832.4	832.4	-
	Сумд	1349.5	1349.5	-
	Нийт	2,181.9	2,181.9	-
2-р улирал	Аймаг	1,188.6	1,188.6	-
	Сумд	2,113.8	2,113.8	-
	Нийт	3,302.4	3,302.4	-
3-р улирал	Аймаг	1,278.6	1,278.6	-
	Сумд	2,023.8	2,023.8	-
	Нийт	3,302.4	3,302.4	-
4-р улирал	Аймаг	1,507.4	1,507.4	-
	Сумд	2,396.7	1,892.3	504.4
	Нийт	3,904.1	3,399.7	504.4
Нийт	Аймаг	4,807.0	4,807.0	-
	Сумд	7,883.8	7,379.4	504.4
	<b>Нийт</b>	<b>12,690.8</b>	<b>12,186.4</b>	504.4

Эх сурвалж: Аймгийн СТСХ

Аймаг сумдын ОНХС-ийн санхүүжилтийг тайлангийн жилийн 4 дүгээр улиралд Цэнхэр суманд 260.1 сая төгрөг, Төвшрүүлэх суманд 244.3 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

ОНХС-ийн орлогын шилжүүлгийн 43.2 хувийг 1, 2 дугаар улиралд, 56.8 хувийг 3,4 дүгээр улиралд олгохоор хуваарийг хийсэн бөгөөд 4 дүгээр улиралд санхүүжилтийг өндөр дүнгээр хуваарилан олгож байгаа нь тухайн онд төлөвлөсөн төсөл арга хэмжээ цаг хугацаандаа хэрэгжихгүй, он дамжих эрсдэлийг бий болгож байна.

**1.1.4.** Аймаг, сумын ИТХ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-д заасны дагуу эх үүсвэрийг 5,244.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.



## Хүснэгт № 5. ОНХС-ийн эх үүсвэр

(сая төгрөг)

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлийг ИТХ-аас баталсан (СЯ-ны э-тайлангаас урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх дүнгээр авсан)	4,051.5		(4,051.5)
2	Төсвийн тухай хуулийн 60.2.4 дахь заалтын хүрээнд Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр	440.8	680.8	240.0
73	Малын тоо толгойн татварын орлого	752.2	1,324.2	572.1
<b>Нийт эх үүсвэр</b>		<b>5,244.5</b>	<b>2,005.0</b>	<b>(3,239.5)</b>

Аймаг, сумдын ИТХ-аас өмнөх оны ОНХС-ийн үлдэгдлээс 2,589.9 сая төгрөг, өмнөх оны малын тоо толгойн албан татварын орлогоос 1,461.7 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар<sup>3</sup> 440.8 сая төгрөг, тайлант оны малын тоо толгойн албан татвараас<sup>4</sup> 752.1 сая төгрөг, нийт 5,244.5 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөж баталсан. (Судалгааны дэлгэрэнгүйг хавсралт судалгаа №1-ээс харна уу.)

Аймаг, орон нутгийн онцлог нөхцөл байдалтай уялдуулан орон нутгийн суурь болон нийт орлогын зөрүүгээр аймгийн ОНХС-д дараах татварын орлогын хувь хэмжээг 440.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Үүнд:

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 192.2 сая төгрөг
- Газрын төлбөр 109.6 сая төгрөг
- Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 90.0 сая төгрөгөөр
- Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг 37.8 сая төгрөг
- Улсын тэмдэгтийн хураамжийг 11.0 сая төгрөгөөр
- Бичил худалдааны татвар 0.2 сая төгрөг

Харин гүйцэтгэлээр 680.8 сая төгрөг буюу төлөвлөснөөс 240.0 сая төгрөгөөр давж биелсэн нь өмнөх оны ОНХС-ийн аудитаар хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажилласантай холбоотой байна.

Сумдын ОНХС-д малын тоо толгойн албан татварын орлогоос (МТТАТ) 752.2 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,324.2 сая төгрөг төвлөрснийг аймгийн СТСХ-ийн мэдээгээр гүйцэтгэлээр 1,126.5 сая төгрөг төвлөрч 197.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

МТТАТ-ын 2024 оны орлогыг 19 сумын хэмжээнд нийт 2,375.4 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч аймгийн хэмжээнд 2022, 2023 онуудад дараалан өвөлжилт хүндэрснээс мал сүрэг олноор хорогдож, малчдын амьжиргааны түвшинд нөлөөлсөнтэй холбогдуулан 11 сумын ИТХ-аар малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг “0” төгрөгөөр баталсантай холбоотой төсвийн тодотголоор татварын орлогыг 752.1 сая төгрөг болгон бууруулан төлөвлөсөн байна.

## Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймаг, сумдын ИТХ-аар ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэх дүн 4,051.5 сая төгрөгөөр баталсан бөгөөд ОНХС-ийн дансанд оны эхэнд 3,091.7 сая төгрөг үлдэгдэлтэй

<sup>3</sup> Төсвийн тухай хуулийн 60.2.4. татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

<sup>4</sup> 60.2.8. малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардал зарцуулна.



тайлагнагдаж, 959.8 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь сумын төсвийн орлогын дансанд төвлөрсөн МТТАТ-ын орлогыг ОНХС-ийн дансанд төвлөрүүлээгүй холбоотой байна.

- ✓ Эрдэнэбулган сум нь МТТАТ-ын орлогыг 72.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 106.3 сая төгрөгийн орлого бүрдсэн байна. Тайлангийн жилд сумын ОНХС-гийн дансанд 72.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 33.4 сая төгрөгийг төвлөрүүлэлгүй орон нутгийн төсвийн орлого дансанд үлдээсэн байна.
- ✓ Сумдын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн өвс, тэжээлийн орлого 34.5 сая төгрөгийг сангийн дансанд төвлөрүүлэлгүйгээр ЗДТГ-ын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлжээ.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 60 дугаар зүйлийн 60.2-т "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ" үүнд 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого ..." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт:** Аудитаас ОНХС-ийн эх үүсвэрийг бүрэн төлөвлөж бүрдүүлэх арга хэмжээг авч ажиллах албан шаардлага, зөвлөмжийг аймаг, сумын Засаг даргад хүргүүлжээ.

## 1.2. Сумдын ИТХ нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталдаг зөрчил давтагдсаар байна

1.2.1. Аймаг, сумын түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах, тухайн хөрөнгө оруулалтын ач холбогдол, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1<sup>5</sup>, 63.2<sup>6</sup>, 63.3<sup>7</sup>, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 5<sup>8</sup>, 6<sup>9</sup>, 7<sup>10</sup> дугаар зүйлд заасан.

Журамд заасны дагуу сумын Засаг даргаас томилсон ажлын хэсэг, багийн Засаг дарга нар 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд иргэд олон нийтэд нээлттэй асуулга явуулж, давхардсан тоогоор 122,346 санал авчээ.

Дүрслэл №1 Иргэдийн санал өгсөн байдал



Нийт саналын 78.9 хувь буюу 96,582 саналыг цаасаар, 18.8 хувь буюу 22,951 саналыг бүлгийн ярилцлагаар, 2.3 хувь буюу 2,813 цахимаар авсан байна. Иргэдээс 30,270.8 сая төгрөгийн таамагт төсөвт өртөгтэй 800 төсөл арга хэмжээнд санал өгчээ. Нийт саналаас 17,935.3 сая

<sup>5</sup> Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

<sup>6</sup> Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

<sup>7</sup> Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ

<sup>8</sup> Тав. Баг, хорооны түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх

<sup>9</sup> Зургаа. Сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх

<sup>10</sup> Долоо. Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн төлөвлөх



төгрөгийн 401 санал батлагдаж, 12,335.5 сая төгрөгийн таамагт төсөвт өртөгтэй 403 санал цуцлагдсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт судалгаа 2-оос харна уу/

ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн санал өгсөн байдлыг хөдөлмөрийн насны хүн амын тоотой харьцуулж үзэхэд Архангай аймгийн нийт хөдөлмөрийн насны иргэдийн 30.8 хувь нь хамрагдсан байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад 7.8 хувиар өссөн хэдий ч ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоо хангалтгүй, иргэдийн идэвх оролцоо сул байна.

Иймд цаашид иргэд олон нийтэд ОНХС-ийн талаарх мэдээлэл түгээх, үйл ажиллагааг үр дүнтэй арга хэлбэрээр зохион байгуулж, сангийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, саналыг хүртээмжтэй байдлаар авах, цахим техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэрийг ашиглан ажиллах зайлшгүй шаардлага үүсэж байна.

ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3<sup>11</sup> 60.3.6<sup>12</sup> дахь заалт, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.3.2<sup>13</sup> заалтуудтай нийцүүлэн үзэхэд нийт батлагдсан 401 ТАХ-ны 20.4 хувь буюу 1,939.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 82 ТАХ нь иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлэгдээгүй байна. Тухайлбал: Жаргалант, Төвшрүүлэх, Цахир сумдын баталсан ТАХ-ны 56.4-85.9% нь иргэдийн саналд үндэслэгдээгүй байна.

Дүрслэл №2 Иргэдийн саналтай болон саналгүй ТАХ



#### ОНХС-ийн талаарх мэдлэг, мэдээллийн талаар:

Аудитын явцад ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн идэвх оролцооны талаарх санал асуулгыг гүүгл форум (google forum) ашиглан 229 иргэнээс цахимаар санал авч нэгтгэхэд дараах байдалтай байна.

Та 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд саналаа өгсөн үү ?

73.6%



26.4%



- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд саналаа өгсөн үү ? гэсэн асуултад нийт оролцогчдын 73.6 хувь нь “Тийм” гэж хариулсан бол 26.4 хувь нь “Үгүй” гэж хариулсан байна.

<sup>11</sup> Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:

<sup>12</sup> орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

<sup>13</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

- Төсөл арга хэмжээний саналыг ямар хэлбэрээр өгсөн бэ? гэсэн асуултад 52.8 хувь нь “Багийн иргэдийн нийтийн хурал дээр цаасаар”, 16.6 хувь нь “Гар утасны аппликейшнээр” 4.8 хувь нь “ОНХС-ийн удирдлага мэдээллийн системээр” 3.9 хувь нь “Бүлгийн ярилцлагаар” гэсэн бол 21.8 хувь “Санал өгөөгүй” гэж хариулсан байна.



- ОНХС-ийн мэдээллийг хаанаас авдаг вэ ? гэсэн асуултад оролцогчдын 54.6 хувь нь багийн иргэдийн нийтийн хурлаас , 16.2 хувь нь Гар утасны аппликейшин, телевиз, радио, олон нийтийн сүлжээнээс, 14.4 хувь нь удирдлага мэдээллийн системээс, 5.7 хувь нь Гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олноос гэж хариулсан бол 9.2 хувь нь мэдээлэл авдаггүй гэжээ.

#### Аудитын илрүүлэлт:

- ✓ Өлзийт сум 32.0 сая төгрөгийн 2, Эрдэнэмандал сум 37.0 сая төгрөгийн 4, Жаргалант сум 202.0 сая төгрөгийн 13, Хашаат сум 33.0 сая төгрөгийн 5, Хотонт сум 99.8 сая төгрөгийн 5, Цэцэрлэг сум 103.7 сая төгрөгийн 5, Цэнхэр сум 294.5 сая төгрөгийн 17, Төвшрүүлэх сум 751.7 сая төгрөгийн 16, Өндөр-Улаан сум 160.4 сая төгрөгийн 8, Тариат сум 74.3 сая төгрөгийн 5, Эрдэнэбулган сум 30.0 сая төгрөгийн 1, Цахир сум 120.7 сая төгрөгийн 1, нийт 1,939.1 сая төгрөгийн иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй 82 ТАХ-г сумдын ИТХ-аар баталж, хэрэгжүүлсэн байна.

**Шийдвэрлэлт:** Аудитаас дээрх иргэдийн саналгүйгээр баталж, хэрэгжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, иргэд олон нийтийн оролцоог хангуулан ажиллах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумдын ИТХ, Засаг дарга нарт хүргүүлээ.

**Иргэдийн саналаар дэмжигдээгүй 1,939.1 сая төгрөгийн 82 төсөл, арга хэмжээ нь аудитаар илэрсэн нийт зөрчлийн 23.5 хувийг эзэлж байх тул аудитаас хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь зүйтэй байна.**

**1.2.2.** Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9<sup>14</sup>, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2<sup>15</sup>, 63.3<sup>16</sup>, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1<sup>17</sup>, 4.1.3<sup>18</sup>-т заасныг үндэслэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймаг, сум нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан батлахаар хуульчилсан.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 401 ТАХ-г аймаг, сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөө болон аймаг, сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа мөрийн хөтөлбөр, аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан

<sup>14</sup> Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

<sup>15</sup> Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

<sup>16</sup> Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн ажлын алба ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлд өргөн мэдүүлнэ.

<sup>17</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

<sup>18</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх;



авч үзэхэд 91.5 хувь буюу 17,305.9 сая төгрөгийн 367 ТАХ нь уялдаж, 8.5 хувь буюу 629.4 сая төгрөгийн 34 ТАХ нь уялдаагүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

- ✓ Батцэнгэл сум 29.0 сая төгрөгийн 2, Өлзийт сум 92.2 сая төгрөгийн 5, Эрдэнэмандал сум 9.0 сая төгрөгийн 3, Төвшрүүлэх сум 18.0 сая төгрөгийн 1, Өндөр-Улаан сум 52.3 сая төгрөгийн 4, Тариат сум 179.2 сая төгрөгийн 5, Эрдэнэбулган сум 140.7 сая төгрөгийн 4, Жаргалант сум 109.0 сая төгрөгийн 10, 629.4 сая төгрөгийн 34 ТАХ сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

**Шийдвэрлэлт:** Аудитаас аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан баталж хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах 8 албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.

**1.2.3.** ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг ИТХ-д өргөн барьж, батлуулахдаа тухайн шатны Засаг дарга төсөвлөлтийн шаардлагыг хангуулж техник эдийн засгийн үндэслэл зураг, төсөв, эдийн засгийн тооцоо судалгааг хийсэн байх үүрэгтэй.

ОНХС-ийн аудитаар Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2<sup>19</sup>, 29.4<sup>20</sup>, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.3, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3<sup>21</sup> дахь заалтын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023-2024 он дамжин хэрэгжсэн 138.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ихтамир сумын арьс шир боловсруулах цэгийн барилга, 341.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн мал нядалгааны цэгийн барилга, 2024 онд хэрэгжүүлсэн 99.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тус нядалгааны цэгийн хөргүүрийн барилга зэрэг ТАХ-үүд нь цаашид үйл ажиллагаа явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усны шугамыг ямар эх үүсвэрээр бий болгох нь тодорхойгүй, ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцоолол хийгдээгүй, төсөвт үзүүлэх ачааллыг урьдчилж тооцоолоогүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г аймгийн ИТХ-аар баталж хэрэгжүүлснээс цаашид үр ашигтай ажиллах эсэх нь тодорхойгүй, төсвийн үрэлгэн зардлыг бий болгосон, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгаагүй байгаа тул дээрх ТАХ-г орон нутагт үр дүнтэйгээр ашиглах бодиттой арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

**Шийдвэрлэлт:** Аудитаас тус хөрөнгүүдийн зориулалтын дагуу ашиглаж, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-аар баталж, хэрэгжүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ-ын даргад хүргүүллээ.

<sup>19</sup> 29.2-т "Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна"

<sup>20</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

<sup>21</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх



**1.2.4. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2<sup>22</sup>-т аймаг, нийслэлийн түвшинд, 4.4<sup>23</sup>, 4.5<sup>24</sup>-т сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүргийг тус тус заасан. Аймагийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 17,935.3 сая төгрөгийн 401 ТАХ-г хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталж, гүйцэтгэлээр 324 ТАХ-нд 14,272.6 сая төгрөгийг зарцуулсан байна.**

ОНХС-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний 291 буюу 89.8 хувийг сумын ОНХС-аар, 33 ТАХ буюу 10.2 хувийг аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэнд 5,993.6 сая төгрөгийг зарцуулсныг журмын дагуу ангилан авч үзвэл:

Дүрслэл №3. Аймаг, нийслэлийн чиг үүрэг хувиар:



- ✓ “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи” чиг үүргийн хүрээнд 10 ТАХ-нд 1,992.2 сая төгрөг
- ✓ “Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ” чиг үүргийн хүрээнд 5 ТАХ-нд 772.0 сая төгрөг
- ✓ “Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах” чиг үүргийн хүрээнд 6 ТАХ-нд 1,519.2 сая төгрөг
- ✓ “Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах” чиг үүрэгт 1 ТАХ-нд 199.7 сая төгрөг
- ✓ Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах” чиг үүрэгт 4 ТАХ-нд 279.4 сая төгрөг
- ✓ “Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх” чиг үүргийн хүрээнд 4 ТАХ-нд 380.0 сая төгрөг
- ✓ “Ажлын байр бий болгох” чиг үүргийн хүрээнд 2 ТАХ-нд 565.3 сая төгрөг
- ✓ Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй 285.9 сая төгрөгийн 1 ТАХ байна.

(Дэлгэрэнгүйг хавсралт судалгаа 3-аас харна уу)

Сумдын түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 365 ТАХ-нд 11,659.7 сая төгрөг төлөвлөснөөс 324 ТАХ-нд 8,279.0 сая төгрөг зарцуулсныг журмын дагуу ангилан авч үзвэл:

<sup>22</sup> Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.


<sup>23</sup> Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

<sup>24</sup> Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.



Дүрслэл №4. Сум, дүүргийн чиг үүрэг хувиар:

- ✓ “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи” чиг үүргийн хүрээнд **35** ТАХ-нд 1,307.1 сая төгрөг
- ✓ “Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ” чиг үүргийн хүрээнд **49** ТАХ-нд 1,641.5 сая төгрөг
- ✓ “Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах” чиг үүргийн хүрээнд **85** ТАХ-нд 2,738.1 сая төгрөг
- ✓ МТТАТ-ын орлогоос чиг үүргийн дагуу **97** ТАХ-нд 1,811.7 сая төгрөг
- ✓ “Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах” чиг үүргийн хүрээнд **9** ТАХ-нд 276.6 сая төгрөг
- ✓ “Сумын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах” чиг үүргийн хүрээнд **6** ТАХ-нд 102.3 сая төгрөг
- ✓ “Ажлын байр бий болгох” чиг үүргийн хүрээнд **7** ТАХ-нд 334.7 сая төгрөг
- ✓ “Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа” чиг үүргийн хүрээнд **1** ТАХ-нд 8.5 сая төгрөг
- ✓ Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй 57.6 сая төгрөгийн **2** ТАХ байна.
- ✓ (Дэлгэрэнгүйг хавсралт судалгаа 4-өөс харна уу)



- “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи”
- “Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ”,
- “Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах”
- Малын тоо толгойн албан татвараас
- Бусад

“ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүрэгт нийцээгүй ТАХ-г хэрэгжүүлсэн дараах зөрчил илэрсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 285.9 сая төгрөгийн өртөгтэй “Багийн Засаг дарга нарыг мотоцикл, тоног төхөөрөмжөөр хангах” төсөл арга хэмжээ нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.2-т заасан аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй байна.
- ✓ Жаргалант сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 27.6 сая төгрөгийн “ЗДТГ-ын төрийн албан хаагчдын 2 айлын барилгад их завсар хийх” ТАХ нь “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүрэгт хамаарахгүй байна.
- ✓ Хайрхан сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах” 50.0 сая төгрөгийн ТАХ-ний хүрээнд 30.0 сая төгрөгийн өртөгтэй хөшөө барьсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.3.1 дэх заалт болон ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүрэгт хамаарахгүй байна.

**Шийдвэрлэлт:** Аудитаас ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүрэгт хамааралгүй ТАХ-г төлөвлөхгүй байх арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.




## БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 97.3 ХУВЬ НЬ ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА

**2.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийг баримтлан ажиллаж байгаа хэдий ч зарим сумд санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна**

**2.1.1** Аймгийн хэмжээнд 2024 онд шинээр нийт 15,542.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 311 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Тендер худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ТАХ-ний:

Дүрслэл № 5.Тендер, ХАА зохион байгуулалт

- 13.2 хувь буюу 7,436.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 41 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтаар,
- 21.2 хувь буюу 4,561.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 66 ТАХ-г харьцуулалтын аргаар,
- 3.5 хувь буюу 519.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээг хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар,
- 1.3 хувь буюу 76.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 ТАХ-г шууд гэрээ байгуулах аргаар,
- 0.3 хувь буюу 7.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ТАХ-г олон нийтийн оролцоотой худалдан авалтаар,
- 60.5 хувь буюу 2,941.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 188 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт судалгаа 5-аас харна уу)*



Тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны 60.5 хувь нь тендерийн босго үнээс доош буюу шууд худалдан авалт эзэлсэн нь төсөвт өртгийг хэт жижиглэж, урсгал шинжтэй арга хэмжээнд зарцуулж байгааг харуулж байна.

### Аудитын илрүүлэлт:

- ✓ Батцэнгэл сумын ИТХ нь "Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалт"-ыг батлахдаа Малын тэжээлийн ургамал тариалах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 40.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг баг тус бүрт нь жижиглэн хувааж батлан шууд худалдан авалт хийсэн.
- ✓ Хайрхан сум нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 31.1.1-31.1.3 дахь заалт, ЗГ-ын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг зөрчиж, 4000 л айргийг 28.0 сая төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн байна

**Шийдвэрлэлт:** Аудитаас дээрх зөрчлийг таслан зогсоож, ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөж, худалдан авалтыг журмын дагуу зохион байгуулж ажиллах албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.



**2.1.2** Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 401 төсөл арга хэмжээнд 17,935.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 69.0 хувь буюу 12,383.2 сая төгрөгийн 298 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 3,688.3 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ хэрэгжих шатандаа байна.

Харин ОНХС-ийн эх үүсвэр дутагдсан, зарласан тендерт оролцогч ирээгүйгээс худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон, оройтсон, төсөвт өртөг хүрэлцээгүй зэргээс шалтгаалан 2,645.5 сая төгрөгийн 78 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Хүснэгт № 6 ОНХС-ийн 2024 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ

(сая төгрөг)

Сумын нэр	ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, ТАХ-ний		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн ТАХ-ний		Дутуу хэрэгжсэн ТАХ-ний		Огт хэрэгжээгүй ТАХ-ний	
	тоо	Дүн	тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Дүн
Ихтамир	27	721.8	20	518.3	20	518.3	-	-	7	188.6
Чулуут	22	500.7	19	465.6	19	465.6		-	3	29.5
Хангай	7	364.3	6	352.7	5	313.2	1	39.4	1	12.4
Тариат	18	518.2	16	426.2	15	396.4	1	29.8	2	38.0
Өндөр-Улаан	29	487.0	26	507.1	26	507.1	-	-	3	88.7
Эрдэнэмандал	21	576.0	16	1,349.5	12	215.9	4	1,133.6	5	82.1
Жаргалант	33	686.9	30	640.0	28	526.2	2	113.7	3	39.2
Цэцэрлэг	16	487.6	12	317.2	10	243.3	2	73.9	4	150.9
Хайрхан	10	338.8	6	297.6	5	248.6	1	49.0	4	61.7
Батцэнгэл	18	512.6	13	437.8	12	420.9	1	16.9	5	65.0
Өлзийт	16	341.8	10	172.8	10	172.8		-	6	154.6
Өгийнуур	7	309.2	6	272.5	6	272.5	-	-	1	35.2
Хашаат	21	437.3	17	362.7	17	362.7		-	4	61.5
Хотонт	13	456.4	11	414.8	10	326.0	1	88.8	2	40.3
Цэнхэр	30	1,648.4	25	1,250.4	23	675.6	2	574.7	5	346.6
Төвшрүүлэх	35	1,361.0	23	850.3	20	739.5	3	110.7	12	487.1
Булган	14	337.9	13	302.5	13	302.5		-	1	32.1
Эрдэнэбулган	17	922.7	13	968.1	12	963.1	1	5.0	4	203.2
Цахир	11	289.0	8	109.9	8	109.9			3	178.8
<b>Сумдын дүн</b>	<b>365</b>	<b>11,297.6</b>	<b>290</b>	<b>10,015.8</b>	<b>271</b>	<b>7,780.2</b>	<b>19</b>	<b>2,235.7</b>	<b>75</b>	<b>2,295.4</b>
<b>Аймаг</b>	<b>36</b>	<b>6,637.8</b>	<b>33</b>	<b>6,055.7</b>	<b>27</b>	<b>4,603.1</b>	<b>6</b>	<b>1,452.6</b>	<b>3</b>	<b>350.0</b>
<b>Нийт дүн</b>	<b>401</b>	<b>17,935.3</b>	<b>323</b>	<b>16,071.5</b>	<b>298</b>	<b>12,383.2</b>	<b>25.0</b>	<b>3,688.3</b>	<b>78</b>	<b>2,645.4</b>

Аймаг, сумын Засаг дарга нар төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5<sup>25</sup>, 41 дүгээр зүйлийн 41.2.2<sup>26</sup>, "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 8.5<sup>27</sup>, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх,

<sup>25</sup> Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

<sup>26</sup> Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

<sup>27</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно



санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12<sup>28</sup> дахь заалт, гүйцэтгэгч захиалагчийн хооронд байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүйгээс ОНХС-ийн санхүүжилтийг төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, зориулалт бус зарцуулдаг зөрчил давтагдан гарсаар байна.

#### Аудитын илрүүлэлт:

Гэрээ дүгнээгүй, ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгоогүй ТАХ-ний тухайд:

- ✓ Ихтамир сум нь бүрэн хэрэгжүүлсэн 511.6 сая төгрөгийн 20, Өгийнуур сум нь бүрэн хэрэгжүүлсэн 269.9 сая төгрөгийн 6, Цэнхэр сум нь бүрэн хэрэгжүүлсэн 1,012.1 сая төгрөгийн 24 ТАХ-ний гэрээг дүгнээгүй санхүүжилтийг олгосон
- ✓ Хайрхан сум нь Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах ажлын ажлын даалгаварт заагдсан ажил бүрэн хийгдээгүй байхад 3.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон.
- ✓ Эрдэнэмандал сум нь 73.7 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг ажлын даалгаварт заагдсан ажил бүрэн хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.
- ✓ Цэцэрлэг сум 73.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагуудад нийт 22.2 сая төгрөгийг урьдчилан олгосон боловч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгэж дуусгаагүй он дамжсан байна.
- ✓ Тариат сум 29.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тэрхийн голд мотоциклын гүүр барих ажлын гүйцэтгэгчид гэрээний дагуу 8.9 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон боловч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй он дамжсан байна.

Зориулалт бус зарцуулсан ТАХ-ний тухайд:

- ✓ Өндөр-Улаан сумын ОНХС-аас “Цөм сүргийг үржүүлэх зардал”-д 5.0 сая төгрөгийг төлөвлөн байгууллагын малчинд хөдөлмөрийн гэрээ байгуулан цалин хөлс олгосон байна.
- ✓ Чулуут сум нь баяр наадмын зардлыг жишиг нормыг 14.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

**Шийдвэрлэлт:** Аудитаар дээрх зөрчлийг арилгаж, гүйцэтгэгч байгууллагаар дутуу хийгдсэн ажлуудыг гүйцэтгүүлэн хүлээн авах, зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

## 2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 97.3 хувь нь төлөвлөсөн зорилтот түвшний үр дүнд хүрсэн байна

2.2.1 Аймгийн хэмжээнд бүрэн хэрэгжсэн 298 төсөл, арга хэмжээнээс 290 төсөл, арга хэмжээ буюу 97.3 хувь нь төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн бол 545.2 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ буюу 2.7 хувь нь зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Хүснэгт №7 Зорилтот түвшинд хүрсэн байдал

(сая төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Төсөл, арга хэмжээний зорилтот түвшний үр дүнд			
		тоо	гэрээний дүн	хүрсэн ТАХ		хүрээгүй ТАХ	
				тоо	дүн	тоо	дүн
А		1	2	3	4	5	6
1	Ихтамир	20	518.3	19	499.3	1	19.0
2	Чулуут	19	465.6	18	445.6	1	20.0
3	Хангай	5	313.2	3	59.9	2	253.3
4	Тариат	15	396.4	15	396.4		0.0
5	Өндөр-Улаан	26	507.1	26	507.1		0.0
6	Эрдэнэмандал	12	215.9	12	215.9		0.0
7	Жаргалант	28	526.2	28	526.2		0.0
8	Цэцэрлэг	10	243.3	10	243.3		0.0

<sup>28</sup> “Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно”,



9	Хайрхан	5	248.6	5	248.6		0.0
10	Батцэнгэл	12	420.9	10	405.9	2	15.0
11	Өлзийт	10	172.8	10	172.8		0.0
12	Өгийнуур	6	272.5	6	272.5		0.0
13	Хашаат	17	362.7	17	362.7		0.0
14	Хотонт	10	326.0	10	326.0		0.0
15	Цэнхэр	23	675.6	23	675.6		0.0
16	Төвшрүүлэх	20	739.5	20	739.5		0.0
17	Булган	13	302.5	13	302.5		0.0
18	Эрдэнэбулган	12	963.1	12	963.1		0.0
19	Цахир	8	109.9	8	109.9		0.0
	<b>Сумдын дүн</b>	<b>271</b>	<b>7,780.2</b>	<b>265</b>	<b>7,472.8</b>	<b>6</b>	<b>307.3</b>
20	Аймаг	27	4,603.1	25	4,365.2	2	237.9
	<b>Нийт дүн</b>	<b>298</b>	<b>12,383.2</b>	<b>290</b>	<b>11,838.0</b>	<b>8</b>	<b>545.2</b>

Хүснэгтээс харахад Ихтамир, Чулуут, Хангай, Батцэнгэл сумдын 1-7 ТАХ, аймгийн 2 ТАХ нь зорилтод түвшиндээ хүрээгүй байна.

#### Аудитын илрүүлэлт:

Төсөл, арга хэмжээний зорилтод түвшний үр дүнд хүрээгүй ТАХ-ний тухайд:

- ✓ Ихтамир сум дотуур байрны халуун усны ажлын гүйцэтгэл хангалтгүй ажлын даалгаврын дагуу хийгдээгүй байхад ажлыг хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон.
- ✓ Чулуут сум сумын угталт үдэлтийн талбайг тохижуулах, засварлах ажил ажлын даалгаврын дагуу хийгдээгүй дутуу хийгдсэн байхад ажлыг хүлээн авч гэрээг дүгнэж санхүүжилтийг бүрэн олгосон.
- ✓ Хангай сум тайлант онд хэрэгжүүлсэн 253.3 сая төгрөгийн 2 ТАХ-ны гүйцэтгэл хангалтгүй ажлын даалгаврын дагуу хийгдээгүй байхад ажлыг хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон.
- ✓ Батцэнгэл сум 423.8 сая төгрөгийн 13 ТАХ-нд сумын ИТХ-ын хууль, эрх зүй, хяналт шалгалт, өргөдөл гомдлын хорооноос 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллахад 15.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ хүрэх зорилтод түвшинд хүрээгүй байгаа зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгуулах 3 заалт бүхий зөвлөмжийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 17 тоотойр албан бичиг хүргүүлэн ажилласан боловч сумын Засаг даргаас зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.

**Шийдвэрлэлт:** Аудитаас дээрх зөрчилд зөрчлийг арилгаж, гүйцэтгэгч байгууллагаар дутуу хийгдсэн ажлуудыг гүйцэтгүүлэн хүлээн авч, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

### 2.3. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт сайжирсан байна

**2.3.1.** Аймгийн хэмжээнд ОНХС-ын хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний 98.3 хувийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн 98.3 хувь буюу 12,091.3 сая төгрөгийн 293 төсөл арга хэмжээг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа бол 1.0 хувь буюу 173.8 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг зориулалт бусаар ашиглаж байна.

#### Хүснэгт №8 Хөрөнгийн ашиглалтын байдал

(сая төгрөг)

Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт					
			Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж буй ТАХ		Зориулалтын бус ашиглаж буй ТАХ		Огт ашиглаагүй ТАХ	
	тоо	гэрээний дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	2	3	4	5	6	7	8	9



Ихтамир	20	518.3	19	499.3			1	19.0
Чулуут	19	465.6	19	465.6				
Хангай	5	313.2	5	313.2				
Тариат	15	396.4	15	396.4				
Өндөр-Улаан	26	507.1	25	502.1	1	5.0		
Эрдэнэмандал	12	215.9	12	215.9				
Жаргалант	28	526.2	28	526.2				
Цэцэрлэг	10	243.3	10	243.3				
Хайрхан	5	248.6	5	248.6				
Батцэнгэл	12	420.9	12	420.9				
Өлзийт	10	172.8	10	172.8				
Өгийнуур	6	272.5	6	272.5				
Хашаат	17	362.7	17	362.7				
Хотонт	10	326.0	10	326.0				
Цэнхэр	23	675.6	23	675.6				
Төвшрүүлэх	20	739.5	20	739.5				
Булган	13	302.5	12	272.5	1	30.0		
Эрдэнэбулган	12	963.1	12	963.1				
Цахир	8	109.9	8	109.9				
Сумдын дүн	271	7,780.2	268	7,726.1	2	35.0	1	19.0
Аймаг	27	4,603.1	25	4,365.2	1	138.8	1	99.1
Нийт дүн	298	12,383.2	293	12,091.3	3	173.8	2	118.1

(Дэлгэрэнгүйг хавсралт судалгаа 7-оос харна уу )

Харин бүрэн хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээний 0.7 хувь буюу 118.1 сая төгрөгийн үнийн дүн бүхий 2 төсөл арга хэмжээг ажлын даалгаврын дагуу гүйцэтгээгүй, чанарын шаардлага хангаагүй, гүйцэтгэл дутуу хийгдсэнтэй холбоотой огт ашиглаагүй байна.

**Дүрслэл№ 6. Ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ**

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 298 төсөл арга хэмжээгээр хэрэгжсэн хөрөнгийн ашиглагч байгууллагын чанарын үнэлгээг хийхэд 95.0 хувь нь ашиглалт сайн, 2.7 хувь нь ашиглалт дунд, 2.3 хувь нь ашиглалт муу байна. Ашиглагч байгууллагаас авсан судалгаагаар Ихтамир сумын 106.9 сая төгрөгийн Цэцэрлэгт хүрээлэн биеийн тамирын талбайг өргөжүүлэх ажил, Чулуут сумын 20.0 сая төгрөгийн угталт үдэлтийн талбайг тохижуулах ажил, Эрдэнэмандал сумын 64.6 сая төгрөгийн Эрдэнэмандал сумын хүндэтгэлийн цогцолбор барих ажил, 9.1 сая

төгрөгийн гүүрний далан засвар, арчилгаа тохижилтын ажил, Жаргалант сумын 113.7 сая төгрөгийн наадмын талбай, Эрдэнэ толгой орчинд цэцэрлэгт хүрээлэн байгуулах тохижилтын ажил, Өлзийт сумын 29.9 сая төгрөгийн Мал нядалгааны газар, Булган сумын 30.0 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зэрэг ТАХ-г ашиглагч байгууллагын чанарын үнэлгээгээр дунд гэж үнэлсэн байна.

Аудитаар ашиглалтгүй хөрөнгөтэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

Зориулалт бус ашиглаж буй төсөл арга хэмжээний тухайд:



- ✓ Булган сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 30.0 сая төгрөгийн өвс тэжээлийг 2024 оны 01-р сарын 05-ны өдрийн сумын онцгой комиссын хуралдаанаар 4 багийн айл өрхүүдэд үнэ төлбөргүй тараасан байна.
- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023-2024 он дамжин хэрэгжсэн 138.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ихтамир сумын арьс шир боловсруулах цэгийн барилгын зарим ажлын гүйцэтгэл дутуу, чанар байдал хангалтгүй, ашиглагч байгууллагын зүгээс зориулалтаар нь ашиглах боломжгүй гэж үзэн бүртгэл тайланд тусгаагүй ба одоогоор Ихтамир сумын ЗДТГ нь агуулахын зориулалтаар ашиглаж байна.

**Огт ашиглагдаагүй төсөл арга хэмжээний тухайд:**

- ✓ Ихтамир сумын 19.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дотуур байрны халуун усны ажлын гүйцэтгэл хангалтгүй ажлын даалгаврын дагуу хийгдээгүй тул ашиглагч байгууллага огт ашиглаагүй байна.
- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн мал нядалгааны цэгийн хөргүүрийн барилга барих 99.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй төсөл арга хэрэгжилтийг газар дээр нь очиж шалгахад зарим ажлыг дутуу хийсэн, чанар байдал хангалтгүй, чанар стандартын шаардлага хангаагүй гэх шалтгаанаар ашиглагч байгууллага үндсэн хөрөнгөнд бүртгээгүй ашиглалтгүй байна.

**Шийдвэрлэлт:** Аудитаас дээрх зөрчлийг арилгаж, гүйцэтгэгч байгууллагаар дутуу хийгдсэн ажлуудыг гүйцэтгүүлэн хүлээн авах, зөрчлийг таслан зогсоох арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

**Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн мал нядалгааны цэгийн хөргүүрийн барилгын зураг**



**Ихтамир ЕБС-ийн дотуур байрны халуун усны газрын зураг**



**Ихтамир сумын арьс шир боловсруулах цэгийн барилгын зураг**





*Дээрх байдлаас харахад захиалагч талаас төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлага, хүртэх үр өгөөж, холбогдох тооцоо бодитой тооцоогүй, гүйцэтгэгч нар ажил, үйлчилгээг чанаргүй гүйцэтгэсэнээс зарим суманд ашиглалтгүй хөрөнгүүд бий болж, тухайн орон нутагт ажлын байр нэмэгдэх, эрүүл, аюулгүй амьдрах орчин бүрдэх, иргэдийн орлого нэмэгдэх боломжийг алдсан байна.*

**2.3.2.** “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтад “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасны дагуу нийт 9,395.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн 99.8 хувь нь ЗДТГ-т бүртгэлтэй байгаа бөгөөд хадгалалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 14,272.6 сая төгрөгийн 324 төсөл арга хэмжээгээр 5,406.4 сая төгрөгийн төсөвт байгууллагын, 3,988.7 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн нийт 9,395.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 511.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 4,366.0 сая төгрөгийн урсгал шинжтэй ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

*ОНХС-ийн хөрөнгийг урсгал шинжтэй арга хэмжээнд зарцуулж байгаа нь сангийн үр нөлөөг бууруулж байна.*

Аудитаар Дарга, Тэргүүлэх аудиторын баталсан 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн “Сумдад ажиллах удирдамж”-ийн дагуу Ихтамир, Өндөр-Улаан, Тариат, Хангай, Чулуут, Батцэнгэл, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал, Жаргалант, Эрдэнэбулган сумдад 2025 оны 06 сарын 09-ний өдрөөс 2025 оны 06 сарын 15-ны өдрүүдэд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээнүүдийг ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг газар дээр нь шалгахад зөрчил дутагдал илрээгүй байна.



Өмнөх жилүүдэд нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцаж байгаа байгууллагын хяналт сулаас хөрөнгө эзэнгүйдэж, эвдэрч гэмтэн ашиглалтгүй болох асуудал цөөнгүй гарч байсан тул аймаг, сумын хэмжээнд гэрэлтүүлэг, камержуулалтын ажлыг ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжүүлснээр дээрх зөрчлүүд арилж, эвдэрч гэмтээсэн тохиолдолд эзэн холбогдогчийг тогтоож, нөхөн төлүүлж ажилласнаар хөрөнгийн хадгалалт хамгаалалт сайжирсан байна.

*Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилт, ашиглалт, хамгаалалтын талаар авсан санал асуулгын тухайд:*

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих буй төсөл арга хэмжээний явцад танд мэдээлэл өгөх, тайлагнах үйл явц хангалттай байсан уу? гэсэн асуулгад нийт оролцогчдын 42.5 хувь нь “Тийм” гэж хариулсан бол 36.7 хувь нь “Дунд зэрэг” 20.8 хувь нь “Үгүй” гэж хариулсан байна.
- Та 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд сэтгэл хангалуун байна уу? гэсэн асуулгад 37.1 хувь нь “Тийм”, 40.6 хувь нь “Дунд зэрэг” 13.5 хувь нь “Хангалтгүй” 8.7 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан байна.



- Та 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар үнэлгээ өгнө үү? гэсэн асуулгад оролцогчдын 34.6 хувь нь “Хангалттай”, 40.8 хувь нь “Дунд зэрэг” 16.2 хувь нь “Хангалтгүй” 8.3 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан байна.

### Сайн жишээ:

- ✓ Батцэнгэл сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн 106.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гудамж талбайн тохижилт”-ын ажлыг Зэвсэгт хүчний 342 дугаар анги гүйцэтгэж, сумын төвийн 2км замыг сайжруулсан бөгөөд 79.0 сая төгрөгийн хандивын хөрөнгөөр тус сайжруулсан замыг асфальтаар хучсан нь бага төсвөөр сумын төвдөө засмал замтай болж орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй ажил хийгджээ.



- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Тамир зуслангийн их завсар, тохижилт”-ын ажил нь хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ая тухтай орчныг бүрдүүлж, хүүхдийн хөгжилд бодит хувь нэмэр оруулсан, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хийгдсэн ач холбогдолтой ажил болжээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн “Авто худаг, усны төв” нь өөртөө үйлчлэх 3ш автомат түгээгүүртэй ба давхар шүүлтүүр ашиглаж байгаа орчин үеийн технологи болох Reverse Osmosis (RO) буюу урвуу осмосын мембран шүүлтүүр ашиглан өндөр даралтаар шүүлтүүрт усыг шахах замаар усны бохирдлыг 99%-ийн үр дүнтэй шүүсэн усыг аймгийн төвийн хүн амд түгээж байна.



## БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТЫН 86.7 ХУВЬД ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

### 3.1. ОНХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна

3.1.1. Нийт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 50.0 хувьд аймаг, сумдын ИТХ, 86.7 хувьд дотоод аудитын нэгжээс хяналт хэрэгжүүлээгүй байна.



"ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 3.2.2<sup>29</sup>, 9.4<sup>30</sup>, 9.5<sup>31</sup>-т ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон тус журмын хэрэгжилтэд аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хороо, иргэний нийгмийн байгууллагууд, дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллага нь хяналт тавьж ажиллахаар заасан

Журмын хүрээнд 2024 онд гүйцэтгэсэн 324 төсөл арга хэмжээнд хяналт хэрэгжүүлсэн эсэхийг аймаг, сумаас ирүүлсэн тайлан, судалгааг авч нэгтгэн авч үзэхэд шат, шатны ИТХ-аас 162, дотоод аудитын нэгжээс 43 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлжээ. Өөрөөр хэлбэл: ИТХ-аас нийт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 50.0 хувьд, дотоод аудитын нэгжээс 13.3 хувьд хяналт хийсэн байна.

Дүрслэл №7 ОНХС-ийн хяналт



Хүснэгт №9 ОНХС-ийн хяналт аймаг, сумаар

(сая.төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээ		ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасан хяналтыг хэрэгжүүлсэн эсэх							
				ИТХ				Дотоод аудит			
				Тийм		Үгүй		Тийм		Үгүй	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	9	10	11	12	13	14	15	16
1	Ихтамир	20	511.6			20	511.6			20	511.6
2	Чулуут	19	465.6	5	131.7	14	333.9			19	465.6
3	Хангай	6	323.3	6	323.3					6	323.3
4	Тариат	16	402.3	16	402.3					16	402.3
5	Өндөр-Улаан	26	374.0			26	374.0			26	374.0
6	Эрдэнэмандал	16	489.6			16	489.6			16	489.6
7	Жаргалант	29	608.8	29	608.8			29	608.8		
8	Цэцэрлэг	12	265.4	12	265.4					12	265.4
9	Хайрхан	6	272.8	6	272.8					6	272.8
10	Батцэнгэл	14	423.9	14	423.9					14	423.9
11	Өлзийт	10	172.8			10	172.8			10	172.8
12	Өгийнуур	6	269.9	6	269.9			6	269.9		
13	Хашаат	17	362.7	17	362.7					17	362.7
14	Хотонт	11	388.1			11	388.1			11	388.1
15	Цэнхэр	24	1,012.1	14	825.0	10	187.1			24	1,012.1
16	Төвшрүүлэх	25	849.0	25	849.0					25	849.0

<sup>29</sup> Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих

<sup>30</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

<sup>31</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ.



17	Булган	13	302.5	1	54.0	12	248.5			13	302.5
18	Эрдэнэбулган	13	674.6	3	263.5	10	411.1			13	674.6
19	Цахир	8	109.9	8	109.9			8	109.9		
	Сумдын дүн	291	8,278.9	162	5,162.2	129	3,116.7	43	988.6	248	7,290.3
20	Аймаг	33	5,993.6			33	5,993.6			33	5,993.6
	Нийт дүн	324	14,272.6	162	5,162.2	162	9,110.3	43	988.6	281	13,283.9

Аймгийн хэмжээнд 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд ИТХ болон дотоод аудитын хяналтыг хэрэгжүүлсэн байдлыг өмнөх онтой харьцуулж үзэхэд:

- ✓ Сумдын ИТХ-ын хяналт 8.5 хувиар, Дотоод аудитын нэгжийн хяналт 2.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгтээс харахад 14 сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлж, дотоод аудитын нэгж нь 3 суманд хяналт хэрэгжүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 33 төсөл арга хэмжээнд аймгийн ИТХ-ын хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй мөн Санхүүгийн хяналт аудитын албанаас аймаг, сумын ОНХС-ийн 2024 оны хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 324 ТАХ-ний 13.3 хувь буюу 43 ТАХ-нд хяналт, шалгалт хийж, 86.7 хувь буюу 281 ТАХ-нд хяналт тавьж ажиллаагүй байна.
- ✓ Ихтамир сум 20, Чулуут сум 14, Өндөр-Улаан сум 26, Эрдэнэмандал сум 16, Өлзийт сум 10, Хотонт сум 11, Цэнхэр сум 10, Булган сум 12, Эрдэнэбулган сум 10 ТАХ-нд сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэлт:** Аудитаас дээрх зөрчлийг арилгах ОНХС-ийн журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлага, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлээ.

**3.1.2.** Сангийн сайдын 2021 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.3.3<sup>32</sup>, 3.3.5<sup>33</sup>, 3.4.3<sup>34</sup>-т заасны дагуу ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтэд аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нар нь хяналт тавьж, цаашид авах хэмжээг зохион байгуулан ажиллахаар заасан.

#### Дүрслэл №8 Захиалагчийн хяналт



Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 14,272.6 сая төгрөгийн 324 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдлыг авч үзвэл 12,150.9 сая төгрөгийн 238 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, 2,121.7 сая төгрөгийн 86 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт судалгаа 8-аас харна уу)

Нийт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 26.5 хувьд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдлыг өмнөх онтой харьцуулж үзэхэд 10.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

<sup>32</sup> ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

<sup>33</sup> Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэх цаашид авах арга хэмжээг зохион байгуулах;

<sup>34</sup> Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;



- ✓ Архангай аймгийн Өндөр-Улаан сум 374.0 сая төгрөгийн 26, Эрдэнэмандал сум 156.2 сая төгрөгийн 4, Өгийнуур сум 269.9 сая төгрөгийн 6, Хашаат сумын 362.7 сая төгрөгийн 17, Төвшрүүлэх сумын 849.0 сая төгрөгийн 25, Цахир сумын 109.9 сая төгрөгийн 8 нийт 2,121.7 сая төгрөгийн 86 ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй.

**Шийдвэрлэлт:** Аудитаас дээрх зөрчлийг арилгаж ОНХС-ийн журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

**Захиалагчийн хяналт хангалтгүйгээс тухайн төсөл, арга хэмжээ чанаргүй болох, зорилтот түвшний үр дүнд хүрэхгүй байх, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүсэж байна.**

**3.1.3.** Өмнөх аудитаар нийт 5,078.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 45 албан шаардлага, 3 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсэн бөгөөд аудитын шийдвэрийн биелэлтийг үнэлэхэд 4,794.6 сая төгрөгийн 38 албан шаардлага бүрэн хэрэгжиж, биелэлт 83.7 хувьтай, харин 3 зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна. (Дэлгэрэнгүйг хавсралт зөвлөмжийн биелэлт, судалгаа 9-оос үзнэ үү)

#### Аудитын илрүүлэлт:

- ✓ Өмнөх аудитаар Жаргалант, Цэцэрлэг, Эрдэнэбулган сум нь иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, Өндөр-Улаан сум ОНХС-ийн мэдээллийг шилэн дансны цахим системд мэдээлээгүй, Тариат сум ОНХС-ийн УМС-д мэдээллийг үнэн зөв бүрэн мэдээлээгүй, Эрдэнэмандал, Өлзийт, Эрдэнэбулган сум болон аймгийн ИТХ-аас тайлант хугацаанд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд хяналт тавьж ажиллаагүй, Өндөр-Улаан сум ОНХС-ийн мэдээллийг шилэн дансны цахим системд мэдээлээгүй зэрэг зөрчлүүд давтагдан гарсан тул холбогдох байгууллага, албан тушаалтанд албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

**Шийдвэрлэлт:** Дээрх зөрчлүүдийг давтан гаргасан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах боломжгүй ажлаас чөлөөлөгдсөн тул зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн ажиллалаа.

**3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг удирдлагын мэдээллийн системд бүрэн мэдээлээгүй, 472.6 сая төгрөгийн 3 ТАХ-г бүртгэл тайланд тусгаагүй байна.**

**3.2.1.** “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9.2<sup>35</sup>, 9.9<sup>36</sup>-т заасны дагуу 19 сумын ЗДТГ-аас ОНХС-ийн 2024 оны гүйцэтгэл, зарцуулалтын тайланг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т ирүүлж нэгтгүүлсэн байна. Мөн журмын 9.11<sup>37</sup>-т заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн гүйцэтгэлийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнажээ.

<sup>35</sup> Сум дүүргийн ЗДТГ-ын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана

<sup>36</sup> “Аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж жил бүрийн 03 дугаар сарын 10-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутгийн хөгжлийн сангийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана”

<sup>37</sup> “ОНХС-ийн орлого, зарлага нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийг тухайн аймаг, нийслэлийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэнэ”



**3.2.2.** Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 14,272.6 сая төгрөгийн 324 ТАХ-ний хүрээнд 511.6 сая төгрөгийн бараа материал, 8,922.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, нийт 9,434.0 сая төгрөгийн хөрөнгийг төсөвт байгууллагын данс бүртгэлд тусгасан бол 4,838.6 сая төгрөгийн хөрөнгийн ТАХ-г урсгал зардлаар тайлагнасан байна. Үүнээс 472.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг урсгал зардлаар бүртгэсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 472.6 сая төгрөгийн 3 ТАХ-ний хүрээнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2<sup>38</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2<sup>39</sup>-д төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхээр заасныг зөрчсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн 234.7 төгрөгийн төсөвт өртөг бүхий Хангай сумын ЕБС-ийн их засвар, Ихтамир суманд 2023-2024 онд хэрэгжүүлсэн 138.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арьс шир боловсруулах цэгийн барилга, Эрдэнэбулган сумын 6 багт 2024 онд хэрэгжүүлсэн 99.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй мал нядалгааны цэгийн хөргүүрийн барилга, нийт 472.6 сая төгрөгийн 3 ТАХ-г нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

**Шийдвэрлэлт.** Аудитаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г ашиглагч байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгаж, бүртгэл хяналттай болгох албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

**3.2.3.** ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем (УМС) нь ОНХС-аас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийн санг бүрдүүлэх зорилготой бөгөөд тус төсөл, арга хэмжээ хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих боломжийг бүрдүүлэх, цаашид системээр дамжуулан мэдээллийн сан бүрдүүлж, хуваарилалт, төлөвлөлт хийх, төслийн санхүүжилт, гүйцэтгэлийг удирдах, тайлагнах, үнэлгээ хийхэд ашиглах зорилготой хэрэгжиж эхэлсэн систем юм.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2<sup>40</sup> дахь заалтын дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, хяналт, бүртгэлийг аймаг, сумдын ЗДТГ нь удирдлагын мэдээллийн системд оруулах чиг үүрэгтэй.

Аудитын явцад иргэд олон нийтээс авсан санал асуулгын хувьд ОНХС-ийн “Удирдлагын мэдээллийн системээс” ямар төрлийн мэдээлэл авдаг вэ? гэсэн асуулгад нийт иргэдийн 26.7 хувь нь “Сангийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой”, 16 хувь нь “Худалдан авах ажиллагаатай холбоотой”, 27.6 хувь нь “Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, биелэлттэй холбоотой”, 29.8 хувь нь “Мэдээлэл авдаггүй” гэж хариулсан байна

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 17,935.3 төсөвт өртөгтэй 401 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас удирдлагын мэдээллийн системд 86.3 хувь буюу 346 ТАХ-г

<sup>38</sup> Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

<sup>39</sup>Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна

<sup>40</sup> ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ



бүрэн мэдээлж, 2.7 хувь буюу 11 ТАХ-г дутуу мэдээлж, 11.0 хувь буюу 44 ТАХ-г мэдээлээгүй байна.

Аймаг, сумдын УМС-д мэдээлэл оруулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 10 УМС-д мэдээлэл оруулсан байдал

(сая төгрөг)

№	Сумын нэр	Нийт батлагдсан ТАХ-ний тоо		Удирдлагын мэдээллийн системд					
		Тоо	Мөнгөн дүн	Бүрэн оруулсан		Дутуу хэрэгжсэн		Огт мэдээлээгүй	
				Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Ихтамир сум	27	721.8	27	721.8				
2	Чулуут сум	22	500.6	13	323.8			9	176.9
3	Хангай сум	7	364.3			7	364.3		
4	Тариат сум	18	518.2	9	363.0	4	107.9	5	47.3
5	Өндөр-Улаан сум	29	487.0	7	120.9			22	366.1
6	Эрдэнэмандал сум	21	576.0	21	576.0				
7	Жаргалант сум	33	686.9	33	686.9				
8	Цэцэрлэг сум	16	487.6	8	253.9			8	233.7
9	Хайрхан сум	10	338.8	10	338.8				
10	Батцэнгэл сум	18	512.6	18	512.6				
11	Өлзийт сум	16	341.8	16	341.8				
12	Өгийнуур сум	7	309.2	7	309.2				
13	Хашаат сум	21	437.3	21	437.3				
14	Хотонт сум	13	456.4	13	456.4				
15	Цэнхэр сум	30	1,648.4	30	1,648.4				
16	Төвшрүүлэх сум	35	1,361.0	35	1,361.0				
17	Булган сум	14	338.0	14	338.0				
18	Эрдэнэбулган сум	17	922.7	17	922.7				
19	Цахир сум	11	289.0	11	289.0				
20	Архангай аймгийн ОНХС	36	6,637.8	36	6,637.8				
<b>Дүн</b>		<b>401</b>	<b>17,935.3</b>	<b>346</b>	<b>16,639.2</b>	<b>11</b>	<b>472.2</b>	<b>44</b>	<b>823.9</b>

Аудитын илрүүлэлт:

- ✓ Цэцэрлэг сум 233.6 сая төгрөгийн 8, Өндөр-Улаан сум 366.1 сая төгрөгийн 22, Чулуут сум 176.9 сая төгрөгийн 9, Тариат сум 47.3 сая төгрөгийн 5 ТАХ-г УМС-д огт мэдээлээгүй
- ✓ Хангай сум 364.3 мянган төгрөгийн 7 ТАХ-г дутуу мэдээлсэн байна.

**Шийдвэрлэлт:** Аудитаас "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ыг мөрдөж сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээллийг удирдлагын мэдээллийн системд хугацаанд нь бүрэн мэдээлэх албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

**3.2.4.** Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2<sup>41</sup>, 3.2.2, 6 дугаар зүйлийн 6.1<sup>42</sup>, 6.1.1<sup>43</sup>, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 11 дүгээр хавсралтын хүрээнд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор тогтмол мэдээлэхээр заасан.

<sup>41</sup> Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна.

<sup>42</sup> Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ,

<sup>43</sup> Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор.



Аймгийн хэмжээнд ОНХС-ийн 2024 оны хөрөнгөөр хэрэгжсэн нийт 17,935.3 сая төгрөгийн 401 ТАХ-ний 1.7% буюу 15 ТАХ-ний мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ✓ Цэцэрлэг сум 3 ТАХ -ний мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд огт мэдээлээгүй.
- ✓ Өндөр-улаан сум 4 ТАХ -ний мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд огт мэдээлээгүй.
- ✓ Булган сум 8 төсөл арга хэмжээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд огт мэдээлээгүй байна.

**Шийдвэрлэлт:** Аудитаас Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг хугацаанд нь мэдээлэх албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.



## **ДҮГНЭЛТ:**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Сумд ОНХС-ийн хөрөнгийг эх үүсвэр тус бүрээр бүрэн төлөвлөж, төвлөрүүлэх талаар санаачилгатай ажиллаагүй, өвс тэжээл борлуулсан орлогыг ОНХС-ийн дансанд төвлөрүүлээгүй байна.
2. Сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хэт жижиглэснээс төсөл арга хэмжээнээс олон нийт хүртэх үр өгөөж буурч, чанар, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүн, үр өгөөжийг урьдчилан тооцолгүйгээр урсгал шинжтэй зардалд төлөвлөн зарцуулж байгаа нь сангийн хөрөнгийн үр дүн, үр нөлөөг бууруулж байна.
5. Захиалагч талаас төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлага, хүртэх үр өгөөж, холбогдох тооцоо судалгааг бодитой хийгээгүйгээс аймаг, сумдад чанаргүй, ашиглалтгүй хөрөнгө бий болж, тухайн орон нутагт ажлын байр нэмэгдэх, эрүүл, аюулгүй амьдрах орчин амьдрах орчин бүрдэх, иргэдийн орлого нэмэгдэх боломжийг алдаж байна.
7. ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн байдлыг удирдлагын мэдээллийн систем болон шилэн дансны цахим системд бүрэн мэдээлдэггүй зөрчил арилахгүй байна.

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:** ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТӨД ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО ХАНГАЛТГҮЙ, ИРГЭДИЙН САНАЛААР ДЭМЖИГДЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛЖ ХЭРЭГЖҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ АРИЛАХГҮЙ БАЙНА

***Аудитаар нийт 8,215.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 62 албан шаардлага, 9 зөвлөмжийг холбогдох албан тушаалтуудад хүргүүллээ.***



## **ЗӨВЛӨМЖ:**

### **Аймгийн ИТХ-ын дарга П.Гомбодорж танаа:**

- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4 дэх заалтын дагуу аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хорооны хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх
- ✓ Төсвийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4-т заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аар батлахгүй байхад чиглэсэн холбогдох арга хэмжээг авч ажиллах

### **Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид танаа:**

- ✓ ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4, 9.5-т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хяналт -шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах

**Хавсралт : Зөвлөмжийн биелэлт**

№	Аудитын зөвлөмжийн		Зөвлөмжийн биелэлт		
	Утга	Тоо	Биелэлтийн талаар	Тоо	Хувь
1	Иргэдийн саналаар дэмжигдэн эрэмбэлэгдсэн төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж ажиллах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	8	Жаргалант, Цэцэрлэг, Эрдэнэбулган сум нь иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй зөрчил 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээнүүд дээр давтагдан гарсан хэвээр байгаа тул шийдвэрийн хэрэгжилтийг хангалтгүй байна гэж үнэллээ.	5	62.5
2	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дутуу чанаргүй, хугацаа хэтэрсэн төсөл, арга хэмжээг ажлын даалгаврын дагуу гүйцэтгүүлэх, хүлээн авах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	6	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дутуу чанаргүй, хугацаа хэтэрсэн төсөл, арга хэмжээг ажлын даалгаврын дагуу гүйцэтгүүлж, ажил хүлээн авах ажлын хэсгийг томилон тус ажлыг хүлээн авч, алдаа зөрчлийг арилгаж ажилласан байна. Хэрэгжилтийг нотлох баримтад үндэслэн 100 хувиар тооцож үнэллээ.	6	100.0
3	Хөрөнгийг бүртгэл тайланд тусгуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах	2	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 269.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэбулган сумын “Мал нядалгааны цэг”-ийг дуусаагүй барилгаар орлогод бүртгэсэн байна. /аймгийн ОНӨГ-ын 2024.10.28-ны 352 тоот албан бичиг/	1	90.0
4	ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй ажлыг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхгүй байхад анхаарч ажиллах	1	Аймгийн ИТХ-аар 2024.09.12-ны өдрийн 07 дугаар тогтоолоор ОНХС-өөр хийгдэх 36 төсөл арга хэмжээ батлагдаж, үүнээс он дамжсан 2, шууд зардалд 1, оролцооны 3, тоног төхөөрөмж 9, ажлын даалгавраар 10, зураг төсөвтэй 11 төслийг хэрэгжүүлэн алдаа зөрчлийг арилгаж ажилласан байна. /Аймгийн ЗД-ын 2024.11.22-ны 01/1626 тоот албан бичиг нотлох баримтын хамт/	1	100.0
5	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж, алдаа зөрчлийг таслан зогсоож ажиллах	2	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж, алдаа зөрчлийг таслан зогсоож ажилласан байна. /Аймгийн ИТХ-ын 2024.11.20-ны өдрийн 100 тоот, аймгийн ЗД-ын 2024.11.22-ны өдрийн 01/1625 тоот албан бичиг/	2	100.0
6	ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулж ажиллах, зөрчлийг таслан зогсоох	1	ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулж, зөрчлийг арилгаж ажилласан байна. /Аймгийн ЗД-ын 2024.09.16-ны өдрийн 01/1303 тоот, ГХБХБГ-ын 2024.09.17-ны 791 тоот албан бичиг, нотлох баримтын хамт/	1	100.0
7	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хийлгэж хэвших, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	4	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хийлгэж, зөрчлийг арилгаж ажилласан байна. /Аймгийн ЗД-ын 2024.09.16-ны 01/1298 тоот, Эрдэнэбулган сумын ЗД-ын 2024.11.20-ны 01/428 тоот/	4	100.0
8	УМС-д мэдээллийг үнэн зөв бүрэн байршуулж ажиллах, зөрчлийг арилгах	7	Сангийн яамны баг орон нутагт ажиллахдаа ОНХС-ийн УМС-д үнэн зөв мэдээлэл оруулсан эсэхэд хяналт тавьж, мэдээлэл оруулаагүй болон алдаатай мэдээлэл оруулсныг тухай бүр засуулах арга хэмжээг авч ажилласнаар зөрчил буурсан бөгөөд Тариат сумын зөрчил бүрэн арилаагүй 2024 оны ОНХС-ийн мэдээллийг дутуу оруулсан байна.	6	85.7
9	ИТХ, Дотоод аудитын хяналт, шилэн данс болон бусад зөрчил	17	Эрдэнэмандал, Өлзийт, Эрдэнэбулган сумын болон аймгийн ИТХ-аас тайлант хугацаанд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажиллаагүй зөрчил арилаагүй байна. Мөн Өндөр-Улаан сумын ОНХС-ийн мэдээллийг шилэн дансны цахим системд мэдээлээгүй зөрчилд өгсөн шийдвэр хэрэгжээгүй байна.	13	72.2
НИЙТ ДҮН		48		41	83.7



### ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



#### АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА


Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139  
Утас/Факс: (976) 7033 3231,  
Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,  
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2025.07.01 № 02/998  
танай 2025.07.01 -ны № 361 -т

#### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын төсөлтэй танилцлаа. Тайлбар саналгүй болно.

ОРЛОГЧ



Ч.БАТНАЙРАМДАЛ

*А. Агваарц*  
*Н. Агваарц*  
*Тасмагзоров А.В.И.*

95250040031



## АН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/30

Эрдэнэбулган сум

#### Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн тайлангийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Н.Алтантуяа)-д үүрэг болгосугай.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрх зүйч аудитор (Б.Анхтуяа)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Д.Нэргүйбаатар)-т даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА



Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2025 оны 1 дугаар сарын 12-ний өдрийн /12/ сар тушаалын хавсралт

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-нд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын бүртгэл

Аудитын нэр: "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"

Аудитын код: АРА-2025/31-1-ШТА-ГА

АД	"Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-нд хийсэн аудитаар хүргүүлсэн шийдвэрийн Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мян.төг/			Төрөл	Огноо	Дугаар	Шийдвэр хүргүүлсэн албан тушаалтан
		Тоо						
1	Эрдэнэбулган сумын засаг дарга нь 2024 онд малын тоо толгойн албан татварын орлогоор 72892.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр 106299.7 мянган төгрөгийг төвлөрүүлснээс сумын ОНХС-ийн дансанд 72892.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, 33407.6 мянган төгрөгийг дууту төвлөрүүлсэн байна.	1	33,407.6		Албан шаардлага	2025.07.01	411/А0360212	Эрдэнэбулган сумын Засаг дарга
2	Аймгийн 19 хэмжээнд 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр нийт 494,310.7 мянган төгрөгөөр өвс, тэжээл худалдан авч, 124,943.9 мянган төгрөгийн өвс, тэжээлийг зарцуулан, сумын ЗДТГ-ын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 34,471.5 мянган төгрөгийн өвс тэжээл борлуулсны орлогыг төвлөрүүлсэн байна.	1	34,471.5		Албан шаардлага	2025.07.01	412/А0360212	Аймгийн Засаг дарга
3	Аймаг сумдын ОНХС-ийн эхний үлдэгдлийг аймаг сумдын ИТХ-аар баталсан ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэх дүнтэй уялдуулан авч үзэхэд аймгийн хэмжээнд нийт 959805.2 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	-		Албан шаардлага	2025.07.01	413/А0360212	Аймгийн Засаг дарга
4	Өлзийт сум нь иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлэгдээгүй 32,000.0 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.	1	32,000.00		Албан шаардлага	2025.07.01	414/А0370220	Өлзийт сумын Засаг дарга
5	Эрдэнэмандал сум нь иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлэгдээгүй 37,000.0 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.	1	37,000.00		Албан шаардлага	2025.07.01	415/А0370220	Эрдэнэмандал сумын Засаг дарга
6	Жаргалант сум нь иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлэгдээгүй 201,993.7 мянган төгрөгийн 13 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.	1	201,993.70		Албан шаардлага	2025.07.01	416/А0370220	Жаргалант сумын Засаг дарга
7	Хашаат сум нь иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлэгдээгүй 33,000.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.	1	33,000.00		Албан шаардлага	2025.07.01	417/А0370220	Хашаат сумын Засаг дарга
8	Хотонт сумын нь иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлэгдээгүй 99,834.2 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.	1	99,834.20		Албан шаардлага	2025.07.01	418/А0370220	Хотонт сумын Засаг дарга
9	Цэцэрлэг сум нь иргэдийн санал аваагүй 103,654.3 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталж 2024 онд хэрэгжүүлж ажилласан байна	1	103,654.30		Албан шаардлага	2025.07.01	419/А0371307	Цэцэрлэг сумын Засаг дарга
10	Цэнхэр сум нь иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй 294,457.3 мянган төгрөгийн 17 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.	1	294,457.30		Албан шаардлага	2025.07.01	420/А0371159	Цэнхэр сумын Засаг дарга
11	Төвшрүүлэх сум нь иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлэгдээгүй 751,676.2 мянган төгрөгийн 16 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.	1	751,676.20		Албан шаардлага	2025.07.01	421/А0371159	Төвшрүүлэх сумын Засаг дарга
12	Өндөр-Улаан сум нь иргэдийн санал аваагүй 160,446.3 мянган төгрөгийн 8 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталж, хэрэгжүүлж ажилласан байна.	1	160,446.30		Албан шаардлага	2025.07.01	422/А0371159	Өндөр-Улаан сумын Засаг дарга
13	Тариат сум нь иргэдийн санал аваагүй 74,280.9 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталж 2024 онд хэрэгжүүлж ажилласан байна.	1	74,280.90		Албан шаардлага	2025.07.01	423/А0371307	Тариат сумын Засаг дарга
14	Эрдэнэбулган сум нь иргэдийн саналаар дэмжигдээгүй "3 дугаар сургуулийн автомашины зогсоол хийх" 30000.0 мянган төгрөгийн 1 төсөл арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөн сумын ИТХ-аар баталсан байна.	1	30,000.00		Албан шаардлага	2025.07.01	424/А0360212	Эрдэнэбулган сумын Засаг дарга
15	Цахир сум нь иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлэгдсэн иж бүрэн трактор авах 120,739.6 мянган төгрөгийн ажлын нэршлийг өөрчлөн Хог ачих автомашины худалдаж авахаар сумын ИТХ-аар баталж, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.	1	120,739.60		Албан шаардлага	2025.07.01	425/А0370220	Цахир сумын Засаг дарга
16	Батцэнгэл сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 29,000.0 мянган төгрөгийн 2 арга хэмжээ нь сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.	1	29,000.00		Албан шаардлага	2025.07.01	426/А0370220	Батцэнгэл сумын Засаг дарга
17	Өлзийт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 92,223.6 мянган төгрөгийн 5 арга хэмжээ нь сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.	1	92,223.60		Албан шаардлага	2025.07.01	427/А0370220	Өлзийт сумын Засаг дарга
18	Эрдэнэмандал сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 9,000.0 мянган төгрөгийн 3 арга хэмжээ нь сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөө болон сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдаагүй байна.	1	9,000.00		Албан шаардлага	2025.07.01	428/А0370220	Эрдэнэмандал сумын Засаг дарга
19	Төвшрүүлэх сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 18,000.0 мянган төгрөгийн 1 төсөл арга хэмжээ нь сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.	1	18,000.00		Албан шаардлага	2025.07.01	429/А0371159	Төвшрүүлэх сумын Засаг дарга
20	Өндөр-Улаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 52,250.0 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээ нь сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.	1	52,250.00		Албан шаардлага	2025.07.01	430/А0371159	Өндөр-Улаан сумын Засаг дарга
21	Тариат сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 179,242.1 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээ нь сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.	1	179,242.10		Албан шаардлага	2025.07.01	431/А0371307	Тариат сумын Засаг дарга
22	Эрдэнэбулган сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн "3 дугаар сургуулийн автомашины зогсоол хийх" - 30000.0 мянган төгрөгийн, "1,2,3,4,5,7 дугаар багийн гуу, жалга гудамжны эвдрэл засах" -30000.0 мянган төгрөгийн, "Малчдад сургалт сурталчилгаа сургалт хийх"-20000.0 мянган төгрөгийн, "6 дугаар багт халуун ус барих"- 60716.1 мянган төгрөгийн, нийт 140716.1 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээ нь Сумын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.	1	140,716.10		Албан шаардлага	2025.07.01	432/А0360212	Эрдэнэбулган сумын Засаг дарга
23	Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 109,000.0 мянган төгрөгийн 10 арга хэмжээ нь сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.	1	109,000.00		Албан шаардлага	2025.07.01	433/А0370220	Жаргалант сумын Засаг дарга
24	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023-2024 он он дамжин хэрэгжсэн Ихтамир сумын арьс шир боловсруулах цехийн барилга барих 138821.8 мянган төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ , Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн мал мядалгааны цехийн хөргүүрийн барилга барих 99080.5 мянган төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ нь цаашид үйл ажиллагаа явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усны шугамыг ямар эх үүсвэрээр бий болгох нь тодорхойгүй, ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцоолол хийгдээгүй, төсөвт үзүүлэх ачааллыг урьдчилж тооцоолоогүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.	1	-		Албан шаардлага	2025.07.01	434/А0360212	Аймгийн Засаг дарга



25	Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 27,560.5 мянган төгрөгийн "ЗДТГ-ын төрийн албан хаагчдын 2 айлын барилгын их завсрын ажил нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-д заасан чиг үүрэгт хамаарахгүй байна.	1	27,560.50	Албан шаардлага	2025.07.01	435/A0370220	Жаргалант сумын Засаг дарга
26	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 285890.0 мянган төгрөгийн өртөгтэй "Байгйн Засаг дарга нарыг мотоцикл, тонг төхөөрөмжөөр хангах" төсөл арга хэмжээ нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2-т заасан аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй байна.	1	285,890.0	Албан шаардлага	2025.07.01	436/A0360212	Аймгийн Засаг дарга
27	Хайрхан сумын ОНХС-ын хөрөнгөөр Монгол улсын даян аварга Ц.Чимэд-Очирын бөхийн хөшөөг 30,000.0 мянган төгрөгөөр барьж, Орон нутгийн хөгжлийн сангийн чиг үүрэгт хамаарахгүй ажил төлөвлөж, санхүүжүүлсэн байна.	1	30,000.00	Албан шаардлага	2025.07.01	437/A0360212	Хайрхан сумын Засаг дарга
28	Батцэнгэл сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт"-ыг батлахдаа Малын тэжээлийн ургамал тариалах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 40,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг баг тус бүрт нь жижиглэн хувааж батлан шууд худалдан авалт хийсэн байна.	1	40,000.00	Албан шаардлага	2025.07.01	438/A0370220	Батцэнгэл сумын Засаг дарга
29	Хайрхан сумын ОНХС-аас баяр наадмын зардалд нийт 38,036.1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үүнээс 28,000.0 мянган төгрөгөөр 4,000 л айргийг шууд худалдан авалт хийсэн байна.	1	28,000.00	Албан шаардлага	2025.07.01	439/A0370220	Хайрхан сумын Засаг дарга
30	Хайрхан сумын Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах ажлыг МГАА ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд ажлын даалгаварт заагдсан 3,993.1 мянган төгрөгийн ажил бүрэн хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.	1	3,993.10	Албан шаардлага	2025.07.01	440/A0370220	Хайрхан сумын Засаг дарга
31	Ихтамир сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгөөр бүрэн хэрэгжүүлсэн 5118589.8 мянган төгрөгийн 20 төсөл, арга хэмжээг гэрээг дүгнээгүй санхүүжилтийг олгосон.	1	511,589.80	Албан шаардлага	2025.07.01	441/A0371159	Ихтамир сумын Засаг дарга
32	Өгийнуур сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгөөр бүрэн хэрэгжүүлсэн 269,909.5 мянган төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг гэрээг дүгнээгүй санхүүжилтийг олгосон.	1	269,909.48	Албан шаардлага	2025.07.01	442/A0371159	Өгийнуур сумын Засаг дарга
33	Өндөр-Улаан сум нь 2024 оны ОНХС-ын хөрөнгөөс байгууллагын малчинд хөдөлмөрийн гэрээ байгуулан 5,000.0 мянган төгрөгийн цалинг олгосон байна.	1	5,000.00	Албан шаардлага	2025.07.01	443/A0371159	Өндөр-Улаан сумын Засаг дарга
34	Тариат сумын 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлсэн 29,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Тэрхийн голд мотоциклын гүүр барих ажлын гүйцэтгэгч "Дэжид лэл" ХХК-нд гэрээний дагуу урьдчилж 8940.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй он дамжсан байна.	1	29,800.00	Албан шаардлага	2025.07.01	444/A0360212	Тариат сумын Засаг дарга
35	Цэнхэр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгөөр бүрэн хэрэгжүүлсэн 1,012,106.1 мянган төгрөгийн 24 төсөл, арга хэмжээг гэрээг дүгнээгүй санхүүжилтийг олгосон.	1	1,012,106.10	Албан шаардлага	2025.07.01	445/A0371159	Цэнхэр сумын Засаг дарга
36	Чулуут сумын ОНХС-аас баяр наадмын зардалд баяр наадмын зардалын жишиг нормыг хэтрүүлэн 14,996.8 мянган төгрөг зарцуулсан байна.	1	14,996.80	Албан шаардлага	2025.07.01	446/A0371307	Чулуут сумын Засаг дарга
37	Цэцэрлэг сумын 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлсэн 73,897.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагуудад нийт 22169.2 мянган төгрөгийг урьдчилан олгосон боловч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгэж дуусгаагүй он дамжсан байна.	1	73,897.50	Албан шаардлага	2025.07.01	447/A0371307	Цэцэрлэг сумын Засаг дарга
38	Эрдэнэмандал сумын ОНХС-ийн хөрөнгөөр 73,737.9 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээг МГАА ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд ажлын даалгаварт заагдсан ажил бүрэн хийгдээгүй байхад санхүүжилтийг 100 хувь олгосон.	1	73,737.90	Албан шаардлага	2025.07.01	448/A0370220	Эрдэнэмандал сумын Засаг дарга
39	Батцэнгэл сумын ИТХ-ын хууль, эрх зүй, хяналт шалгалт, өргөдөл гомдлын хорооноос 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллахад 15,000.0 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээ хүрэх зорилгод түвшиндөө хүрээгүй байгаа зөрчлийг арилгуулах 3 заалт бүхий зөвлөмжийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 17 тоотор албан бичиг хүргүүлэн ажилласан боловч сумын Засаг даргаас зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.	1	15,000.00	Албан шаардлага	2025.07.01	449/A0370220	Батцэнгэл сумын Засаг дарга
40	Чулуут сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Сумын утгалт үзэлтийн талбайг тохижуулах, засварлах" ТАХ нь ажлын даалгаврын дагуу хийгдээгүй дутуу хийгдсэн байхад ажлыг хүлээн авч гэрээг дүгнэж санхүүжилтийг бүрэн олгосон байна.	1	20,000.00	Албан шаардлага	2025.07.01	450/A0371307	Чулуут сумын Засаг дарга
41	Хангай сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 253,345.0 мянган төгрөгийн 2 ТАХ-ны гүйцэтгэл хангалтгүй ажлын даалгаврын дагуу хийгдээгүй байхад ажлыг хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна.	1	253,345.04	Албан шаардлага	2025.07.01	451/A0371159	Хангай сумын Засаг дарга
42	Ихтамир сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Дотуур байрны халуун усны ажил"-ын гүйцэтгэл хангалтгүй ажлын даалгаврын дагуу хийгдээгүй байхад ажлыг хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна.	1	19,000.00	Албан шаардлага	2025.07.01	452/A0371159	Ихтамир сумын Засаг дарга
43	Булган сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 30,000.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг сумын онцгой комиссын 2024 оны 01-р сарын 05-ны өдрийн хуралдаанаар 4 багийн айл өрхүүдэд үнэ төлбөргүй тараасан байна.	1	30,000.00	Албан шаардлага	2025.07.01	453/A0371307	Булган сумын Засаг дарга
44	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023-2024 он он дамжин хэрэгжсэн Ихтамир сумын арьс шир боловсруулах цехийн барилга барих 138821.8 мянган төгрөгийн гэрээний дүнтэй ажил, Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн мал мядалгааны цехийн хөргүүрийн барилга барих 99080.5 мянган төгрөгийн гэрээний дүнтэй төсөл арга хэрэгжилтийг газар дээр нь очиж шалгахад зураг төсөв, ажлын даалгаврын гүйцэтгээгүй, гүйцэтгэл дутуу, чанар байдал хангалтгүй, ашиглагч байгууллагын зүгээс зориулалтаас нь ашиглах боломжгүй, чанарын шаардлага хангаагүй гэх шалтгаанаар үндсэн хөрөнгөндөө бүртгээгүй ашиглалтгүй байгаа нь төсвийн хөрөнгийн үр дүн, үр нөлөөг бууруулж байна.	1	237,902.30	Албан шаардлага	2025.07.01	454/A0360212	Аймгийн Засаг дарга
45	Өлзийт сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн 172,767.9 мянган төгрөгийн 10 төсөл арга хэмжээнд сумын ИТХ-аас хяналт шалгалт хийгдээгүй байна.	1	-	Албан шаардлага	2025.07.01	455/A0370220	Өлзийт сумын Засаг дарга
46	Эрдэнэмандал сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 489,599.6 мянган төгрөгийн 15 төсөл арга хэмжээнд сумын ИТХ-аас хяналт тавьж ажиллаагүй.	1	-	Албан шаардлага	2025.07.01	456/A0370220	Эрдэнэмандал сумын Засаг дарга
47	Хотонт сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн 388,139.9 мянган төгрөгийн 11 төсөл арга хэмжээнд сумын ИТХ-аас хяналт шалгалт хийгдээгүй байна.	1	-	Албан шаардлага	2025.07.01	457/A0370220	Хотонт сумын Засаг дарга
48	Эрдэнэмандал сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 156,255.4 мянган төгрөгийн 4 ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй.	1	156,255.40	Албан шаардлага	2025.07.01	458/A0370220	Эрдэнэмандал сумын Засаг дарга



49	Хашаат сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 362,657.3 мянган төгрөгийн 17 ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, гэрээ дүгнэж ажиллаагүй.	1	362,657.28	Албан шаардлага	2025.07.01	459/A0370220	Хашаат сумын Засаг дарга
50	Төвшрүүлэх сумын ОНХС-ийн 2024 оны хөрөнгөөр санхүүжүүлж гүйцэтгэсэн 848,993.4 мянган төгрөгийн 25 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	1	848,993.40	Албан шаардлага	2025.07.01	460/A0371159	Төвшрүүлэх сумын Засаг дарга
51	Өгийнуур сумын ОНХС-ийн 2024 оны хөрөнгөөр санхүүжүүлж гүйцэтгэсэн 272,464.2 мянган төгрөгийн 6 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	1	272,464.20	Албан шаардлага	2025.07.01	461/A0371159	Өгийнуур сумын Засаг дарга
52	Өндөр-Улаан сумын ОНХС-ийн 2024 оны хөрөнгөөр санхүүжүүлж гүйцэтгэсэн 374,016.1 мянган төгрөгийн 26 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	1	374,016.07	Албан шаардлага	2025.07.01	462/A0371159	Өндөр-Улаан сумын Засаг дарга
53	Цахир сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 109,885.0 мянган төгрөгийн 8 ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй.	1	109,885.00	Албан шаардлага	2025.07.01	463/A0370220	Цахир сумын Засаг дарга
54	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн 234,722.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий Хангай сумын ЕБС-ийн их засвар, Ихтамир суманд 2023-2024 онд хэрэгжүүлсэн 138,821.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй арьс шир боловсруулах цэгийн барилга, Эрдэнэбулган сумын 6 багт 2024 онд хэрэгжүүлсэн 99,080.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй мал нядалгааны цэгийн хөргүүрийн барилга, нийт 472,624.4 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.	1	472,624.4	Албан шаардлага	2025.07.01	464/A0360212	Аймгийн Засаг дарга
55	Цэцэрлэг сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжсэн 233,654.3 мянган төгрөгийн 8 төсөл арга хэмжээг УМС-д байршуулаагүй байна.	1	-	Албан шаардлага	2025.07.01	465/A0371307	Цэцэрлэг сумын Засаг дарга
56	Өндөр-Улаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 366,107.5 мянган төгрөгийн 22 арга хэмжээг Удирдлага мэдээллийн системд огт оруулаагүй байна.	1	-	Албан шаардлага	2025.07.01	466/A0371159	Өндөр-Улаан сумын Засаг дарга
57	Тариат сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 107927.5 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээг дутуу мэдээлж, 47,280.9 мянган төгрөгийн 5 арга хэмжээг Удирдлага мэдээллийн системд огт оруулаагүй байна.	1	-	Албан шаардлага	2025.07.01	467/A0371307	Тариат сумын Засаг дарга
58	Чулуут сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжсэн 176,896.8 мянган төгрөгийн 9 төсөл арга хэмжээг УМС-д байршуулаагүй байна.	1	-	Албан шаардлага	2025.07.01	468/A0371307	Чулуут сумын Засаг дарга
59	Хангай сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжсэн 364,261.5 мянган төгрөгийн 7 төсөл арга хэмжээг УМС-д тайлант онд дутуу байршуулсан байна.	1	-	Албан шаардлага	2025.07.01	469/A0371159	Хангай сумын Засаг дарга
60	Цэцэрлэг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 60,000.0 мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг Шилэн дансны системд огт мэдээлээгүй байна.	1	-	Албан шаардлага	2025.07.01	470/A0371307	Цэцэрлэг сумын Засаг дарга
61	Өндөр-Улаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 47,272.6 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээг Шилэн дансны системд огт мэдээлээгүй байна.	1	-	Албан шаардлага	2025.07.01	471/A0371159	Өндөр-Улаан сумын Засаг дарга
62	Булган сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 196,918.7 мянган төгрөгийн 8 төсөл арга хэмжээг Шилэн дансны системд огт мэдээлээгүй байна.	1	-	Албан шаардлага	2025.07.01	472/A0371307	Булган сумын Засаг дарга
63	Булган сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 248,518.0 мянган төгрөгийн 12 төсөл, арга хэмжээнд сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.	1	-	Зөвлөмж	2025.07.01	120/A0371307	Булган сумын ИТХ-ын дарга
64	Цэнхэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 175,050.0 мянган төгрөгийн 10 төсөл арга хэмжээнд сумын ИТХ-аас хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй.	1	-	Зөвлөмж	2025.07.01	121/A0371159	Цэнхэр сумын ИТХ-ын дарга
65	Ихтамир сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 511,589.8 мянган төгрөгийн 20 төсөл арга хэмжээнд сумын ИТХ-аас хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй.	1	-	Зөвлөмж	2025.07.01	122/A0371159	Ихтамир сумын ИТХ-ын дарга
66	Өндөр-Улаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 374,016.1 мянган төгрөгийн 26 төсөл арга хэмжээнд сумын ИТХ-аас хяналт тавьж ажиллаагүй.	1	-	Зөвлөмж	2025.07.01	123/A0371159	Өндөр-Улаан сумын ИТХ-ын дарга
67	Чулуут сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 333,899.6 мянган төгрөгийн 14 төсөл, арга хэмжээнд сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй.	1	-	Зөвлөмж	2025.07.01	124/A0371307	Чулуут сумын ИТХ-ын дарга
68	Эрдэнэбулган сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 674,658.1 мянган төгрөгийн 13 ТАХ-ний 263,472.1 мянган төгрөгийн 3 ТАХ-нд ИТХ-ын хяналтын хорооноос хяналт хэрэгжүүлж, 411,186.0 мянган төгрөгийн 10 ТАХ-нд хяналт хэрэгжүүлээгүй байна.	1	-	Зөвлөмж	2025.07.01	125/A0360212	Эрдэнэбулган сумын ИТХ-ын дарга
69	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 5,993,580.6 мянган төгрөгийн 33 төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэлд засаг даргын дэргэдэх дотоод аудитын байгууллага хяналт тавьж ажиллаагүй байна. Мөн Өгийнуур, Цахир, Жаргалант сумдаас бусад сумдын 2024 оны ОНХС-ийн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй байна.	1	-	Зөвлөмж	2025.07.01	126/A0360212	Аймгийн Засаг дарга
70	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 5,993,580.6 мянган төгрөгийн 33 төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэлд аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй байна.	1	-	Зөвлөмж	2025.07.01	127/A0360212	Аймгийн ИТХ-ын дарга
71	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023-2024 он он дамжин хэрэгжсэн Ихтамир сумын арьс шир боловсруулах цехийн барилга барих 138821.8 мянган төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ, Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн мал мядалгааны цехийн хөргүүрийн барилга барих 99080.5 мянган төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ нь цаашид үйл ажиллагаа явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усны шугамыг ямар эх үүсвэрээр бий болгох нь тодорхойгүй, ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцролол хийгдээгүй, төсөвт үзүүлэх ачааллыг урьдчилж тооцоолоогүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.	1	-	Зөвлөмж	2025.07.01	128/A0360212	Аймгийн ИТХ-ын дарга
<b>НИЙТ ДҮН</b>		<b>71</b>	<b>8,215,017.67</b>				

